

## **ЗХУ-ЫН ШУА-ИЙН “МОНГОЛЫН КОМИСС”-ЫН МОНГОЛ ДАХЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Ч.БАТДОРЖ

*Доктор (Ph.D)*

*ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн  
Ойрхи үеийн түүхийн салбарын эрхлэгч,*

XIX зууны сүүл XX зууны эхэн болоход Хаант Орос улсын Газарзүйн нийгэмлэгийн олон салбарууд болон Оросын ШУА-ийн олон хүрээлэн, Их сургуулиуд өөр өөрсдийн шинжлэх ухааны чиглэлээр олон удаагийн судалгааны экспедицүүдийг монголд илгээж, ялангуяа байгалийн шинжлэх ухааны судалгаануудыг ихээхэн сонирхох болжээ. Энэ нь Монголчууд тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж, Чин улсаас салснаа албан ёсоор зарлаж, Хаант Орос улсаас тусламж гуйж зээл аван, найрамдлын гэрээ байгуулсан нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр Хаант Оросын харьяат нар ажиллах, судалгаа хийхэд урьд өмнөхөөс таатай нөхцөл бүрдсэнтэй холбоотой юм.

Хаант Орос улсаас Монгол улсад суух санхүүгийн зөвлөх С.А.Козин, түүний орлогч П.А.Витте нарын 1915 онд монголын эдийн засгийн нөөц бололцоо тэр дундаа мал аж ахуй, бэлчээр, ой мод, байгалийн баялаг, ан гөрөө, газар тариалан зэрэг зүйлийг судлахаар 5 багт хуваагдсан 53 хүний бүрэлдэхүүнтэй өргөн хэмжээний судалгааг явуулсан юм. Энэ судалгааны үр дүнд улсын төсвийг тооцон гаргаж, хүн амын тоо болон нийгмийн давхраажилд, гадаадын харьяат нарын тоо, эрүүл мэндийн байдал, өвчлөлт зэргээс гадна малын тоог анх удаа тооцоолон гарсан юм. С.А.Козин, П.А.Витте нарын судалгаа нь Монголын эдийн засгийн нөөц бололцоог судлан гаргаснаар Хаант Орос улсаас Монголын малын гаралтай түүхий эдийн талаар цаашид урт хугацаанд явуулах бодлого, зорилтыг шийдвэрлэхэд чухал эх хэрэглэгдэхүүн болжээ.

Харин 1919-1920 онд Оросын Эрхүү мужийн контороос Монгол-Оросын худалдааны ажлын хэтийн төлөв, нөхцөл боломжийг судлуулахаар эдийн засагч мэргэжилтэй И.М.Майскийг Монгол руу явуулжээ. И.М.Майский 16 сарын туршид Монголд ажиллаад монголчуудын эдийн засгийн үндсэн эх сурвалж болох мал сүргийн тоо толгойг судлахын зэрэгцээ, түүх, шашин, хүн ам нийгмийн давхраа, бие махбод, оюун сэтгэлгээний онцлог зэргээс эхлээд байгаль, цаг уур, гол мөрөн, ургамал, амьтны аймаг хүртэл бүх түвшинд нарийн судалгаа явуулжээ. Монголчуудын мал, монгол айлын өрхийн төсөв, Монгол дахь тээвэр, худалдаа, мөнгөн тэмдэгт, аж үйлдвэр, газар тариалан, үндэсний баялаг, ашиг орлого зэргийг

нарийн судалсан<sup>1</sup> нь урьд өмнө нь Монголд ажилласан бусад судалгаануудаас үндэслэлтэй мэдээллийг агуулснаараа үнэ цэнтэй байв. Мөн Оросууд төдийгүй дэлхийн бусад орны хувьд нууцлагдмал байсан монголчуудын хүн амыг Халхын дөрвөн аймгийн хэмжээнд, хошуу нэг бүрийн хүн, амын тоог гаргаж, хошууг дотор нь нийгмийн давхраа буюу нас хүйсээр ялган гаргасан хамгийн анхны статистик мэдээллийг агуулж байсан юм.

С.А.Козин, П.А.Витте, И.М.Майский нарын судалгаагаар XVIII зуунаас эхлэн Хаант Орос улсаас Монголын талаар явуулсан бодлого, судалгааны чиглэлийн нэгэн үе дуусдаг. Учир нь Хаант Орос улсын зүгээс мэдэхийг хүсэж байсан монголчуудын эдийн засгийн нөөц бололцоо, хүн ард ба цэрэг эрийн тоо, мал аж ахуй хүч чадлыг үндсэндээ тодорхойлж чадсан юм. Тиймээс Монгол орныг судлах судалгааны дараагийн шинэ шат руу оруулах шаардлага урган гарчээ. Энэ нь Монголчууд улс төрийн хувьд шинээр зохион байгуулагдаж буй Зөвлөлт засагтай ойртон нягтарч, тэдний тусламж дэмжлэгээр улс орноо өөд нь татах гэсэн монголчуудын сонирхолтой давхацсан юм.

Зөвлөлт Оросоос Монголд байгалийн ухааны салбарын судалгааг түлхүү оруулж шинжлэх ухааны аль нэг чиглэлээр дагнасан экспедицүүдийг явуулахаар төлөвлөх болжээ. Энэ нь нэгдүгээрт, Монголтой харилцах улс төрийн харилцаанд ашиглагдах геополитикийн судалгаанууд явагдаад, дараа нь эдийн засаг, хүн хүчний талаарх судалгаа үргэлжлээд монгол нутаг дахь байгалийн баялаг, ашигт малтмал, гол мөрөн, ой мод, амьтан ургамал зэргийг олон шинжлэх ухааны чиглэл бүрээр тусгайлан судлах хээрийн шинжилгээ судалгаа хийхэд чиглэгдсэн байна.

1921 оны намар Монголд шинэ тогтсон Ардын Засгийн газрын дэмжлэгээр Судар бичгийн хүрээлэн буюу шинжлэх ухааны анхны байгууллага албан ёсоор байгуулагдаж, Зөвлөлтийн ШУА болон түүний удирдлагууд болон монголч эрдэмтэдтэй холбоо тогтоон хамтран ажиллах, эрдэмтдийг урин ирүүлж, Монгол орныг шинжлэн судлахыг урьсан байна. Үүнтэй давхцан Зөвлөлтийн дотоод, гадаад бодлого тогтворжих болсон нь Оросын ШУА-ийн экспедицийн үйл ажиллагаа идэвхжих боломжийг бүрдүүлжээ.

Монголын баруун хойд хэсэгт судалгаа хийх анхны саналыг 1921 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр болсон Оросын ШУА-ийн Физик-математикийн салбарын хуралдаан дээр П.П.Сушкин Зоологийн музей, Геологи, эрдэсийн музейгээс хамтарсан экспедиц илгээж, өмнө нь явуулж байсан геологи, амьтан судлалын судалгааг үргэлжлүүлэх төслийг танилцуулсан байна. Харин 1921 оны 10 дугаар сарын 1-ний өдөр болсон Оросын ШУА-ийн ерөнхий чуулганы хуралдаан дээр С.Ф.Ольденбург Зоологийн музей болон Геологи, эрдэсийн музейн хамтарсан төслийг танилцуулжээ. Мөн эдгээр экспедицүүдийг удирдан зохион байгуулах комисс байгуулах саналыг оруулжээ. Тус хурлаас дээрх саналыг дэмжиж, С.Ф.Ольденбургийг өөрийг нь шинээр байгуулагдах комиссын даргаар томилсон

<sup>1</sup> И.М.Майский. Монгол орон хувьсгалын босгон дээр. Орос хэлнээс орчуулсан Ч.Баатар. УБ., 2014. Т. 1-294

байна.<sup>2</sup> Энэ хооронд С.Ф.Ольденбург Судар бичгийн хүрээлэнгийн Ж.Цэвээн тэргүүтэй хүмүүстэй захидлаар харилцах болжээ.

Шинээр байгуулагдсан комиссоос Монгол, Тагна Урианхай, Баруун хойд Сибирь зэрэг олон газар экспедицүүдийг илгээхээр төлөвлөсөн ч зөвхөн И.П.Рачковскийн удирдсан геологийн экспедиц Монголын баруун хойд хилийн дагуу болон Урианхайн нутгаар судалгаа хийхээр болжээ.

И.П.Рачковскийн удирдсан геологийн судалгааны ажлыг 5 жилээр төлөвлөж, З.А.Лебедева болон П.П.Сизова нарын геологич нарыг багтаасан 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр 1923 онд хээрийн судалгааны ажил эхэлжээ. Эхний хоёр жилд Тувагийн нутаг, Монгол улсын Ховдын хязгаарын газрын гадаргын шинж чанарыг судлан нэлээд хэдэн өндөр уул нурууд, том жижиг нуур, хотгорууд болон онцгой хэсгүүд болон хуваагдсан бөгөөд Доод төмөрлөгийн далайн тунамлаас гурав дахь галавын эх газар хуримтлагдах хүртэлх геологийн бүрэлдэхүүнийг бараг үндсэн бүх элементүүдтэй танилцсан гэжээ. 1925 оноос Увс нуураас Хангайн нуруу хүртэлх нутгийг судлахаар төлөвлөж, Монголын царцдасын бүтцийг тодорхойлох ажилд чиглэсэн байна. Аливаа улсын геологийн судалгаа хийхэд байр зүйн зураггүйгээр явах боломжгүй байдаг. Монгол улсын хувьд тухайн үед байр зүйн тодорхой зураг байгаагүйн улмаас экспедицийн бүрэлдэхүүнд байр зүйн зураг авах ажлыг давхар хийж байгаа тухай урьдчилсан тайланд тэмдэглэсэн байна.<sup>3</sup>

Судар бичгийн хүрээлэнгийн дарга С.Жамьян, эрдэмтэн нарийн бичгийн дарга Ж.Цэвээн нар болон тус хүрээлэнгийн тэргүүлэгчдийн хурлаас Оросын ШУА-ийн байнгын нарийн бичгийн дарга, академич С.Ф.Ольденбургт илгээсэн захидалд: *“Ноднин жил манай Монгол автономит засгийг халж, Ардын эрхт хэмжээт засгийг үүсгэн явуулснаас хойш Монгол улсын Судар бичгийн хүрээлэн байгуулсан уг зорилт болбоос олон боловсорсон улсын хэлээс манай Монголд анхан дэлгэрсэн элдэв соёл, эрдэм суртлын зэрэг бичгийг орчуулан дэлгэрүүлж, ард түмнийг жолоодон сурган таниулан, боловсруулсугай хэмээсэн ... Олон боловсорсон улсын эрдэмтнийг хүсэх нь, ундаассан усыг хүсэх мэт бөгөөд эрхэм эрдэмтний их түшмэл, яруу алдрыг сонсож хүсэн баярлаж барахгүй. Одоо үүнээс хойш харилцан санаагаа нэвтрэлцэж, үүрд тусламж үзүүлэхийг гуйв. ... мунхаг эр Жамьян, жич гишүүн буриад Жамсран, мунхаг Дашням нар түмэн газрын холоос ёслол”* хэмээн бичжээ.<sup>4</sup>

Энэ хооронд академич С.Ф.Ольденбург хувиасаа болон Оросын ШУА-ийн нэрийн өмнөөс Судар бичгийн хүрээлэнтэй харилцаа тогтоон, хамтран ажиллах санаачилга гаргаж, идэвхтэй харилцааг эхлүүлж, Монголтой холбоотой ном, дэвтрүүдийг Судар бичгийн хүрээлэн руу явуулж байв.

1925 оны 1 дүгээр сард ЗХУ-ын Ардын Комиссариатын Зөвлөлийн газрын дэргэд Монгол ба Тагна Туваг шинжлэх ухааны үүднээс судлах комисс [Монголын комисс]-ыг байгуулсан байна. Тус комиссын зорилго нь Монгол ба Тагна Туваг

2 Т.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. Стр. 69

3 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Тал 25-26

4 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-12, нугалбар 2

шинжлэх ухааны бүхий л чиглэлээр судлах байв.<sup>5</sup> Комиссын даргаар Ардын Комиссариатын Зөвлөлийн газрын бичиг хэргийн эрхлэгч Н.П.Горбунов, орлогч даргад академич С.Ф.Ольденбург, гишүүдэд академич В.Л.Комаров (ботаник), хэл шинжээч Н.Я.Марр, монгол судлаач Б.А.Владимирцов, хөрс судлаач Б.Б.Полынов, газарзүйч А.А.Григорьев, аялагч П.К.Козлов, Оросын ШУА-ийн Зоологийн музейн захирал А.А.Бялиницкий-Бируля, мөн геологич И.П.Рачковский, эрдэс судлаач В.И.Крыжановский, археологич С.А.Теплоухов, археологич Г.И.Боровка, Оросын Газарзүйн нийгэмлэгийн дарга Ю.М.Шокальский нар багтсан байна. Удалгүй мөн оны 4 сарын 2-ны өдөр комисст дахин 2 дахь орлогч даргаар академич эрдэс судлаач А.Е.Ферсман, гишүүдэд геологич В.А.Обручев, ботаникч Н.И.Вавилов нарыг нэмэн оруулжээ.<sup>6</sup>

Комиссын анхны хуралдаан 1925 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Ленинград хотод болж, Монгол ба Тагна Тува руу 8 хэсэг экспедицийг илгээхээр болсон байна. Үүнд, геологи, геохими, хөрс судлал, ботаник зоологи, угсаатан-хэл шинжлэл, археологи-антропологи, археологи гэсэн 8 төрлийн экспедицийг төлөвлөжээ.<sup>7</sup> Экспедицүүдийг Монгол руу илгээхийн урьд санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, Монгол улсын Засгийн газар, Судар бичгийн хүрээлэнтэй урьдчилан тохиролцсон хөрс судлал ба эрдэс судлалын экспедицийн удирдагч Б.Б.Полынов, В.И.Крыжановский нарын багийн төлөвлөгөөг баталсан байна. ЗХУ-ын Ардын Комиссариатын Зөвлөлийн газраас П.К.Козловын экспедицийг бүх талаас нь дэмж гэсэн шийдвэрийн дагуу Б.Б.Полынов, В.И.Крыжановский нарыг 1924 оны зун Монгол руу илгээсэн байдаг. Б.Б.Полынов Монголд ирснийхээ дараа Нийслэл хүрээний орчмын байр зүй болон хөрсний бүрхэвчийг судалсан байна. Харин В.И.Крыжановский Нийслэл хүрээнээс холгүй Туул голын нэгэн эх Горхи орчмын эрдэс баялгийн ордуудыг судалжээ. Тиймээс Б.Б.Полынов, В.И.Крыжановскийн судалгааг Монголд үргэлжлүүлэн ажиллуулахыг Монгол улсын Засгийн газар болон Судар бичгийн хүрээлэнгээс дэмжин, судалгааны ажлын санхүүжилтийн тодорхой хэсгийг гаргахаар болсон байна. Үүнд, морь, тэрэг, баглаа боодол, ажилчин, майхан зэрэгт 2000 рубль, геодезийн багаж хэрэгсэлд 1000 рублийг өгөхөөр тохиролцсон байна.<sup>8</sup> Харин ЗХУ-ын Сангийн Ардын Комиссариатын газраас 30 000 рублийг тус комисст хуваарилсны 25 000 рубль нь хээрийн судалгааны зардал, 5000 рубль нь суурин судалгаанд зарцуулахаар төлөвлөсөн байна.<sup>9</sup>

Монголын комиссоос зохион байгуулах экспедицүүдийн гол хүч нь Оросын ШУА-ийн харьяа олон хүрээлэн, музей зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны газруудын эрдэмтэн судлаачид байв.

5 СПФ АРАН. ф.339, оп.1, д.1, л.67-68

6 Т.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. стр. 85

7 СПФ АРАН. ф.339, оп.1, д.1, л.67-68

8 Т.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. Стр. ...

9 Т.И.Юсупова. Монгольская комиссия Академии наук. История создания и деятельности 1925-1953. СПб., 2006. Стр. 69

Дараагийн экспедиц нь И.П.Рачковскийн удирдсан геологийн отряд, Б.М.Куплетскийн удирдсан геохимийн отрядууд байв. Геологийн отряд 1923-1924 онд Баруун Монголд явуулсан судалгаагаа үргэлжлүүлэн хийхээр болсон бол Б.М.Куплетский Хэрлэн голын сав дагуу зэс ба хар тугалганы ордыг судлах, гянт болд, цагаан тугалга, бал чулуу, үнэт чулуу хайж, хэрэв илрүүлбэл олборлож болох эсэхийг судлахаар төлөвлөжээ.<sup>10</sup> Мөн Г.И.Боровкагийн археологийн отряд, Л.Я.Штернбергийн угсаатны зүйн отряд, Б.Я.Владимирцовын угсаа-хэл шинжлэлийн отряд, А.А.Григорьевын эдийн засгийн газарзүйн отрядыг Монгол руу илгээхээр тус комиссоос төлөвлөжээ.

ЗХУ-ын Ардын Комиссариатын Зөвлөлийн дэргэдэх Монгол – Тагна Туваг судлах комиссын төлөвлөсний дагуу 1925 оны зун дээрх отрядууд Монголд хүрэлцэн ирж, Судар бичгийн хүрээлэн дээр төвлөрөн зохих зөвшөөрлийг авч ажил хэргээ харилцан тохиролцож шийдвэрлэсэн байна. Үүнд, Монголын талаас судалгааны экспедицийн орчуулагч болон дагалдан туслах хүмүүс, аялалд хэрэглэгдэх зүйлд мөнгөн тусламж үзүүлсэн юм.

Оросын эрдэмтэд Монголд ирээд юуны түрүүнд Судар бичгийн хүрээлэнд төвлөн байрлаж, аялалд гарахаасаа урьд тус хүрээлэнгээр дамжуулан Дотоод яаманд мэдэгдэж, тусгайлсан тэмдэг бичгийг авдаг байв.

Хөрс судлалын отрядыг ахалж байсан хөрс судлаач Б.Б.Полынов, ургамал судлаач И.М.Крашениников болон гурван туслах ажилчны хамт Улаанбаатар хотоос гарч Богд хан уулын аймгийн Хүнцэлцавчил уулын хошууны нутаг дахь Төхөм нуурт хүрчээ. Судалгааны баг Улаанбаатараас Төхөм нуур хүртэл 220 км орчим замыг туулахдаа замын гудаст хөрс болон эрдсийн судалгаа хийв. Төхөм нуурт ирээд тухайн бүс нутгийн хөрсний байдлыг шинжлэн үзэхийн зэрэгцээ байрзүйн зураг үйлдэж, геологи, хөрс, ургамлын хатаадас цуглуулсан байна. Үүнээс гадна судалгааны ажлын явц болон, судлагдахуунд холбоотой зүйлсийн гэрэл зургийг авчээ<sup>11</sup>.

Төлөвлөгөөний дагуу ирэх дараагийн отряд нь геологийн отряд байв. Энэ отрядыг И.П.Рачковский ахалж байсан боловч 1925 оны экспедицийг түүний багт ажиллаж байсан З.А.Лебедева ахлан явуулсан байна. Оросын ШУА-ийн Геологийн хүрээлэн нь 1923 оноос эхлэн Баруун Монголд явуулж байсан судалгаагаа үргэлжлүүлэн явуулжээ. З.А.Лебедева Улаанбаатарт ирэлгүйгээр шууд Баруун Монгол буюу Чандмань уулын аймгийн нутаг Хархираагийн уулс, Тогтохын шил зэрэг газарт геологийн судалгаа хийж, геологийн газрын зургийг үйлдсэн байна. Үүнээс гадна зэс болон шөрмөсөн чулууны уурхай байгааг олж тогтоосон байна<sup>12</sup>. Судалгааны үр дүнгээрээ “Умард Монгол” хэмээх сэтгүүлийн нэгдүгээр ботид “Баруун хойд Монголын Хархираагийн уулсын геологийн судалгаа” хэмээх өгүүлэл бичиж нийтлүүлсэн байна.<sup>13</sup> Түүний отрядад геологич, палеоботаникч

10 Т.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. Стр. 86

11 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-161, хуудас 44

12 Мөн тэнд, хуудас 45

13 З.А.Лебедева. Геологические исследования Харкинского массива Северо-Западной Монголии. // Предварительные отчеты геологической, геохимической и почвенно-географической экспедиций о работах, произведенных в 1925 г. Л., 1926. Стр. 7-30

М.Ф.Нейбург оролцжээ.

Оросын ШУА-ийн Эрдэс судлалын музейн судлаач Б.М.Куплетскийн удирдсан геохимийн отряд томоохон бүрэлдэхүүнтэй Монголд ажиллаж, В.И.Крыжановскийн 1924 оны судалгааг үргэлжлүүлэн хийжээ.<sup>14</sup> Энэ отрядын бүрэлдэхүүнд Эрдэс судлаач Е.Е.Лабунцова-Костылева, геологич Н.М.Прокопенко нар явжээ. Судалгааны баг Улаанбаатар хотоос гарч Туул голын дээд бие, Хэрлэн голын эрэг дэх Зүүн хүрэнээс доош уруудан, Тугалгат нуур хүрээд эргээд Улаанбаатар чиглэлтэй явж, замаараа Налайхын чулуун нүүрсний хэмжээг тодорхойлжээ. Тэрээр Налайхын чулуун нүүрсний нөөцийг 2 сая тонн орчим хэмээн тодорхойлсон бол Тугалгат нуурын орчимд тугалга буй эсэхийг судлан үзсэн ч баримтгүй хэмээн тэмдэглэжээ. Мөн газрын орчим ашиг бүхий гянт, зэсийн гялбагануур зэргийг шинжлэн үзжээ. Тэндээс өмнө тийш Хэрлэн, Цэнхэрийн гол хоёрын дунд бүхий газар ашиглагдаагүй болрын судалтай пегматитийг илрүүлсэн байна. Үүнээс гадна Цагаан булаг хэмээн газар шохойн чулууны уурхайн ашиглах байдлыг үзээд, олборлож буй байдал нь ихээхэн бүдүүлэг байгаа тул ашиглах явдлыг сайжруулах талаар зааварчилгаа бичиж үлдээсэн байна<sup>15</sup>.

Геохимийн отрядад ажилласан Е.Е.Лабунцова-Костылева, Н.М.Прокопенкогийн хамт Улаанбаатар хотоос гарч Горхийн уурхай, Гурван баяны уурхай эргээд Улаанбаатар хотын чиглэлд явж судалгаа хийжээ. Энд Горхи болон Гурван баяны уурхайг шинжлэн үзэж, уурхайг хэрхэн ашиглаж болох тухай, хэрэв цаашид ашиглах аваас хэрхэн хөгжүүлэх зэргийг судалжээ.<sup>16</sup> Е.Е.Лабунцова-Костылева, Н.М.Прокопенко нар 1926 онд “Северная Монголия” хэмээх сэтгүүлийн тэргүүн ботид “Хойд Монголын Өргөө орчмын пегматийн судлууд” хэмээх өгүүллийг нийтлүүлжээ.<sup>17</sup>

Монгол улсын Засгийн газар болон Судар бичгийн хүрээлэнгээс геологи, эрдэс баялгийн тухай судалгааг ихээхэн сонирхож, ашиглах боломжтой орд, уурхай байх юм бол эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг хайж байсан учир уурхайн баялаг, үнэт чулууг ихээхэн сонирхож байв.

Судар бичгийн хүрээлэнтэй эртнээс холбоо харилцаатай байсан Оросын ШУА-ийн Азийн музейн профессор Б.Я.Владимирцов угсаа-хэл шинжлэлийн отрядыг удирдан өөрийн шавь оюутан Б.Б.Бамбаев, Ц.Номинханов болон Буриад-Монголын эрдмийн хүрээлэнгийн захирал Барадийн Базар, Судар бичгийн хүрээлэнгийн бичээч Н.Дэндэв нарын хамт явжээ. Улаанбаатараас гарч Туул голын зүүн эргийн уулсаар аялан Бага Хэнтий нуруу хүрч, улмаар Тэрэлжийн адаг хүрээд, Хэрлэнгийн баруун биеэр уруудан Зүүн хүрээ, Жанчивлин хийд, Налайх дахь Тоньюкукийн дурсгалаар дайраад Улаанбаатарт буцаж иржээ.<sup>18</sup> Б.Я.Владимирцовын энэ удаагийн

14 Т.И.Юсупова. Монгольская комиссия Академии наук. История создания и деятельности 1925-1953. СПб., 2006. Стр. 75

15 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-161, хуудас 56

16 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-161, хуудас 54

17 Т.И.Юсупова. Монгольская комиссия Академии наук. История создания и деятельности 1925-1953. СПб., 2006. Стр. 212

18 “Ц-д. Номихановын 1924-1925 онд Баруун Монголд хийсэн судалгаа-II”. УБ., 2016. Т. 178

судалгааны зорилго нь:

1. а) Өргөө [Улаанбаатар] орчмын яриа, ялангуяа нийслэлд суусан монголын олон өөр аймгуудын хүмүүсийн хэл ярианы хувирлыг ажиглах;  
б) Үүний далимаар хэл шинжлэл ба аман зохиолын материалууд цуглуулах;
2. Өргөө [Улаанбаатар]-д цуглуулсан монгол гар бичмэл болон барын номуудтай танилцах;
3. Чингис хааны үеийн түүхэн газар нутгийг магадлан үзэх, эдгээр газрууд нь XII зууны Монголчуудын хүч чадалтай холбоотой эсэхийг судлах байжээ.<sup>19</sup>

Судар бичгийн хүрээлэнгээс бичээч Н.Дэндэвийг дагалдуулан явуулж, нийт 1012 янчаан 47 мөнгийг Б.Я.Владимирцов нарт өгч, судалгааны ажлын санхүүжилт болон хэрэглэгдэх майхан, сав, унаа хэрэглэл зэргийг бүрэн даасан байна. Гэсэн ч аялалд 400 янчааныг л зарцуулж, үлдсэн мөнгийг Судар бичгийн хүрээлэнд хүлээлгэн өгсөн байна.<sup>20</sup>

Б.Я.Владимирцов, Барадийн Базар нар энэ удаагийн аяллаар монгол хэлний халхын аялгууг угсаа, хэл шинжлэлийн үүднээс судлахын дээр дуу, үлгэр зэргийг тэмдэглэн Судар бичгийн хүрээлэнгийн музейд тавих зарим нэгэн үзвэрийг цуглуулжээ. Мөн хэд хэдэн булш малтан судалсан тухай Судар бичгийн хүрээлэнгийн товч тайланд тэмдэглэсэн байна.<sup>21</sup> Үүнээс гадна Барадийн Базарын өдөр тутмын тэмдэглэл бичиг зорчсон газрын маршрутыг тэмдэглэсэн газрын зургийг үйлдэн Судар бичгийн хүрээлэнд өгсөн хэмээжээ. Түүний өдрийн тэмдэглэл нь өдгөө Монгол улсын ШУА-ийн Хэл, зохиолын хүрээлэнгийн гар бичмэлийн санд хадгалагдаж байгаа бөгөөд Б.Я.Владимирцовын шавь халимаг оюутан Номинханов 1924-1925 онд Баруун Монголд хийсэн судалгааны 9 дэвтэр тайлантай хамт хадгалагдаж байгаа тул Барадийн Базарын тайланг Номинхановын тэмдэглэл хэмээн зарим судлаачид андуурсан зүйл байна. 2016 онд Номинхановын бүтээлийг хэвлэхдээ Барадийн Базарын өдрийн тэмдэглэлийг Номинхановын тэмдэглэл хэмээн нийт 10 дэвтрийг хоёр боть болгон хэвлэжээ.

Барадийн Базарын 1925 оны өдрийн тэмдэглэлд хэд хэдэн сонирхолтой зүйл бичжээ. Түүний ажигласнаар халх аялгуу нь бусад монгол аялгуунаас хэлбэрийн хувьд илүү төгс, илүү хялбар ба энэ аялгуу ирээдүйд шинэ Монголын шинэ утга зохиолын хэлний үндэс болох ёстой гэсэн өөрийн таамаглалыг бататгав... халх монгол аялгуу нь авиазүй, үг бүтээвэр, өгүүлбэрзүйн хэлбэр, ярианы өнгө болон өгүүлбэрийн эгнээн дэх дуудах хурдаараа илүү хурдан, нээлттэй байна хэмээн дүгнэжээ.

Их эзэн Чингис хаантай холбоотой түүхэн газруудыг тухайн цагийн оршин суугчдын хэлснээр нарийн тодруулах боломжгүй байна гэдгийг тэмдэглэсэн байна. Нутгийн иргэдийн мэдээллээр Онон, Хэрлэн, Туул, Орхон голуудаас өөр газрыг

19 Б.Я.Владимирцов. Этно-лингвистические исследования в Урге, Ургинском и Кентейском районах. Работы по монгольскому языкознанию. Издательская ферма “Восточная литература” РАН. М, 2005. Стр. 358

20 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Тал 29-30

21 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-161, хуудас 53

тодруулах боломжгүй. Жишээлбэл, эртний Бурхан Халдун нь аль уул болохыг яг таг хэлж чадахгүй байгааг онцолжээ. Чингис хааны бунхныг Их Хэнтий бүсэд хайх ёстой. Чингис хааны оршуулга маш нууц байдалд болсон тул ямар нэг азтай тохиолдол л учрахгүй бол түүний бунхныг олох боломжгүй хэмээн өөрийн саналыг бичжээ.<sup>22</sup> Мөн Зүүнгарын Галдан бошогт хаан болон Чин улсын хаан Канси [Энх-Амгалан] хаантай байлдсан Зуун модыг хайсан боловч эрэл нь үр дүнд хүрээгүй гэжээ. Өдгөө түүхэн газарзүйн судалгаанд Бурхан Халдун уул нь яг аль болох нь судлаачдын дунд маргаантай хэвээрээ байгаа бол Зуун модны тулалдаан болсон газар нь тодорхой болсон юм.

Мөн тус угсаа, хэл шинжлэлийн отряд нь монгол бөөгийн тухай судалгаа хийсэн байна. Барадийн Базар Улаанбаатар хотод болон Тэрэлжид бөөтэй уулзсан бололтой. Тэмдэглэлдээ Улаанбаатарт уулзсан залуу удгантай уулзахаас эхлээд дуустал нь болсон бүх үйл явдлыг нарийн тэмдэглэгээ хийжээ. Түүний бичсэнийг товчилбол, халх маягаар хувцасласан залуу эмэгтэй байсан бөгөөд нэлээд чинээлэг боловч хуучирсан торгон дээл өмсөж, алт, мөнгөөр гэзгээ чимсэн байлаа. Тэгээд титэмтэй хэнгэрэг, дохиур гэх мэт эд зүйлтэй тансаг торгон өмсгөл оруулж ирэв. Хувцсаа солиод гүрмийн зан үйл хийж, ламтай яг адил арц уугиулна. Дараа нь чухал үйл хэрэгт бэлтгэж байгаа мэт өөр хүний дүрд орж эхлэв. Ерөнхийдөө эрхэмсэг төрхтэй. Эхлээд шарын шашны төдийгүй бөө мөргөлийн бүх бурхад, сүнс нарт хандан удиртгал үг хэллээ. Онгодоо удаан дуудсаны эцэст гэнэт мухар хутга шүүрч хэлээ дундуур нь зүсэхэд цус садрав. Удган түүнд өгсөн аяганд цусаа дүүргээд их сүнснүүдийн дүрийн өмнө аягыг тавин тэдэнд өргөл өргөлөө. Түүний онгод орох үед бид түүнээс элдэв зүйл асуухад тэр хэнд гай таарах, хэний биед бузартсан цамц байгаа, хэнээс болгоомжлох тухай шаламгай хариулав. Үүний дараа тэр хэвийн байдалд оров хэмээн бичжээ.<sup>23</sup> Харин Б.Я.Владимирцов монголд уулзсан бөөгийн тухай бичихдээ, бид хоёр бөөтэй уулзсан. Тэрэлжид уулзсан бөөг Санж гэдэг бөгөөд Зэлмэ овогтой, 39 настай, халхын алдартай бөө байв. Нөгөө нь арай ахимаг насны Гомбожав зайран, түүний овог нь Хариад ажээ. Тэр хоёр бөөгийн яриа болон зан үйлд нь буриад бөөгийн нөлөө байгаа нь харагдаж байсан гэжээ. Үүнээс гадна бөөгийн дуудлага болон эдлэл хэрэглэл зэргийг нэг бүрчлэн тэмдэглэн авсан байна<sup>24</sup>. Хээрийн судалгааны бүрэлдэхүүнд явсан Б.Я.Владимирцовын шавь буриад оюутан Б.Б.Бамбаев монголчууд өөрсдөө монгол бичгээр тэмдэглэсэн халх болон өөр бусад олон монгол дууг тэмдэглэсэн цуглуулга, монгол бичгийн өнөөгийн

22 Барадийн Базарын 1925 онд Монгол судалгаа хийсэн өдрийн тэмдэглэл. Ц-д. Номинхановын 1924-1925 он Баруун Монголд хийсэн судалгаа-II. Эрхлэн хэвлүүлсэн Н.Сүхбаатар. Гар бичмэлээс цахим бичвэрт бичиж, хөрвүүлэг, орчуулга хийсэн На.Сүхбаатар, Т.Ганцог. Цувралын редактор: Б.Түвшинтөгс. Ботийн редактор: Ц.Өнөрбаян. УБ., 2016. Т. 178-179

23 Барадийн Базарын 1925 онд Монгол судалгаа хийсэн өдрийн тэмдэглэл. Ц-д. Номинхановын 1924-1925 он Баруун Монголд хийсэн судалгаа-II. Эрхлэн хэвлүүлсэн Н.Сүхбаатар. Гар бичмэлээс цахим бичвэрт бичиж, хөрвүүлэг, орчуулга хийсэн На.Сүхбаатар, Т.Ганцог. Цувралын редактор: Б.Түвшинтөгс. Ботийн редактор: Ц.Өнөрбаян. УБ., 2016. Т. 176-177

24 Б.Я.Владимирцов. Этно-лингвистические исследования в Урге, Ургинском и Кентейском районах. Работы по монгольскому языкознанию. Издательская фирма "Восточная литература" РАН. М., 2005. Стр. 380-390

байдлыг шинжлэхэд хэрэглэх гэсэн зорилгоор 7 дэвтэр зүйл цуглуулжээ<sup>25</sup>.

Археологийн отрядыг Ленинград хот дахь Эрмитаж музейн археологич Г.И.Боровка ахлан явуулжээ. Г.И.Боровка анх 1924 онд П.К.Козловын Монгол-Төвдийн экспедицэд туслахаар ирж байсан бөгөөд 1925 онд Монголын комиссын төлөвлөгөөний дагуу ажиллахаар Монголд ирсэн юм. Г.И.Боровка 7 сарын 31-нд Улаанбаатар хотод ирээд шууд Ноён ууланд ажиллах гэсэн боловч тухайн жил бороо их орж байсан учир явж чадаагүй байна. Тийм учраас Судар бичгийн хүрээлэнгийн хүсэлтээр Туул голын хөндий дэх археологийн дурсгалуудыг судлахаар болжээ<sup>26</sup>. Г.И.Боровкад Судар бичгийн хүрээлэнгээс олгосон тэмдэг бичгийг авч Туул голыг уруудан Богд хан уулын аймгийн Баян-Эрхт, Хутаг-Өндөр, Хүнцэлцавчид уулын хошууны нутгаар явж, Цэцэрлэгийн замаар Улаанбаатар хотод буцан иржээ.<sup>27</sup> Хээрийн судалгааны явцад хадны зураг, эртний түрэгийн булш, тахилын байгууламжаас гадна хэд хэдэн дөрвөлжин булш малтан шинжилсэн байна. Түүний энэ удаагийн судалгааг зарим судлаачид Монгол нутагт дөрвөлжин булшны судалгааг анх хийсэн гэж үздэг ажээ.<sup>28</sup> Нийт 92 булш, бунхан илрүүлэн бүртгэж, малтан судалсан булшнуудаас нь нийт 230 орчим эд өлгийн зүйл гарсны бүртгэл нь УТА-д хадгалагдаж байна.

Г.И.Боровкагийн энэ удаагийн судалгааны ажлын өдрийн тэмдэглэл болон гэрэл зургууд нь ОХУ-ын ШУА-ийн Эдийн соёлын түүхийн хүрээлэнгийн архивд хадгалагдаж байдгийг С.Чулуун, М.В.Медведева нар хамтран “Монгол орон ба Монголчууд” хэмээх гэрэл зургийн цувралын гуравдугаар ботид хэвлэжээ. Энэхүү ботид Г.И.Боровкагийн 1925-1926 онд БНМАУ-д ажиллахдаа авсан 280 орчим гэрэл зураг багтсан байна.

Комиссоос баталсан бусад отряд болох угсаатан судлал, эдийн засгийн газарзүйн отрядууд ямар нэгэн шалтгаанаар Монголд ирж чадаагүй байна.

ЗХУ-ын Ардын Комиссариатын Зөвлөлийн дэргэдэх Монголыг судлах комисс 1925 оны эцэст тухайн жил хийсэн ажлаа төлөвлөн дараагийн төлөвлөгөөг боловсруулжээ. Монголд ажилласан отрядын ахлагч нар тайлан илтгэлдээ БНМАУ-ын Судар бичгийн хүрээлэнгийн дарга С.Жамьян, гишүүн Ж.Цэвээн, В.И.Лисовский нарын тусламж дэмжлэгийг<sup>29</sup> цохон тэмдэглэсэн байна. Хээрийн судалгааны явцад цуглуулсан анхан шатны хөрс, ургамлын дээж, геологийн цуглуулга зэргийг Судар бичгийн хүрээлэнд товч тайлангийн хамт хүлээлгэн өгсөн байна.

1926 онд Монголын комиссоос Г.И.Боровка, Б.М.Куплетский, Б.Б.Полынов нарын судалгааг үргэлжлүүлэн явуулсан бол ботаникч Н.В.Павлов, зоологич А.Я.Тугаринов нарын шинэ хүмүүсийг Монгол руу судалгаа хийлгэхээр явуулсан

25 Б.Я.Владимирцов. Этно-лингвистические исследования в Урге, Ургинском и Кентейском районах. Работы по монгольскому языкознанию. Издательская ферма “Восточная литература” РАН. М.,2005. Стр. 370

26 Монгол орон ба монголчууд III. Эмхэтгэсэн С.Чулуун, М.В.Медведева. УБ-СПб., 2017. Т. 13

27 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-66, хуудас 137

28 Монгол орон ба монголчууд III. Эмхэтгэсэн С.Чулуун, М.В.Медведева. УБ-СПб., 2017. Т. 14

29 Т.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. Стр. 90

байна. Монголын комиссын зүгээс цаашид судалгааны ажлыг өргөтгөх, Судар бичгийн хүрээлэн дээр тулгуурлан ажиллах шаардлага байснаас гадна, БНМАУ-ын зүгээс өөрийн орныг судлуулах сонирхол байсныг харгалзан 1926 онд Монголд ирсэн тус комиссын төлөөлөгчид Судар бичгийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ бичиг үйлджээ. Комиссыг төлөөлж гурван Борис буюу Б.Я.Владимирцов, Б.Б.Полынов, Б.М.Куплетский нар Судар бичгийн хүрээлэнтэй 12 зүйл бүхий гэрээг байгуулсан байна. Гэрээнд, 8 төрлийн отрядыг Монголд ажиллуулах, түүний 2 нь Баруун Монголд, үлдсэн 6 нь Судар бичгийн хүрээлэн дээр төвлөрч судалгаа явуулах, экспедицийн бүх хүмүүс Монгол улсын хууль, цаазыг баримтлан явах, судалгаагаар илрүүлсэн зүйл нь БНМАУ-ын өмч учир судлан шинжлүүлэх зорилгоор Орос руу илгээх бол Судар бичгийн хүрээлэнтэй тохиролцох, хилээр нэвтрүүлэхэд Судар бичгийн хүрээлэн туслах, хээрийн судалгааны ажил дууссаны дараа товч тайлан үйлдэж, Судар бичгийн хүрээлэнд үлдээх, экспедицийн буулгасан газрын зураг болон гэрэл зургийг нэг хувь үйлдэн Судар бичгийн хүрээлэнд хүлээлгэн өгөх тухай заасан байна.<sup>30</sup>

Хөрс судлалын отрядыг Б.Б.Полынов ахлан Судар бичгийн хүрээлэнгийн ажилтан Лисовскийн хамт явсан байна. Б.Б.Полынов 1925 онд явсан маршрутаа үргэлжлүүлэн Улаанбаатар, Төхөм нуур, Мишиг гүн [Дэлгэрхаан уулын хошуу], Сангийн далай, Онгийн гол, Бага хутаг, Замын-Үүд, Улаанбаатар чиглэлтэй явжээ. Аяллын явцад, хөрс судлалын судалгаа хийж, хөрс ба ургамлын цуглуулга хийжээ<sup>31</sup>. Үүнээс гадна нийт явсан 1600 км орчим замын маршрутыг газрын зурагт үйлдэн тэмдэглэсэн байна<sup>32</sup>.

Геохимийн отрядыг дахин Куплетский удирдан явуулжээ. Өмнөх жилийн явсан маршрутыг үргэлжлүүлэн Улаанбаатар, Зүүн хүрээ [Хэрлэн голын], Брэйвүн хийд, Онон гол, Хэрлэн гол, Сэцэн ханы хүрээ [Өндөрхаан], Улаанбаатарын чиглэлд явжээ. Тэрээр явсан газрынхаа геологийн картыг үйлдэж, таван рашааны химийн найрлагыг судлан, шил үйлдэх ба керамик эд зүйлс хийхэд хэрэглэх түүхий эдийг судлах, өөхөн чулууны судлыг тодорхойлж, ашиглаж болохуйц кальцитонин бүхий газрыг тэмдэглэсэн байна. Үүнээс гадна Төхөм нуурын орчимд тусгайлан явж, хүхэртэй рашааныг илрүүлжээ.<sup>33</sup>

Харин 1925 онд Ноён ууланд ажиллахаар ирээд цаг агаарын байдлаас болоод ажиллаж чадаагүй Боровкагийн удирдсан археологийн отряд Ноён ууланд ажилласан байна. Ноён уулан дахь Хүннүгийн язгууртны булшийг судлан шинжлэх ажлыг Монгол-Төвдийн экспедицийн удирдагч П.К.Козлов удирдан явуулж байв. [Энэ тухай өөр зүйлд өгүүлэх болно].

Монголын угсаа, хэл шинжлэлийн отрядын дарга Б.Я.Владимирцов, Н.Н.Поппе нар Монголд ажиллахаар ирсэн боловч, удирдагч нь Бээжинд явсан учир, хээрийн судалгаанд Н.Н.Поппе, Б.Б.Бамбаевтай хамт явж, Орхон голын хөндий, Цагаан

30 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-83, хуудас 1-7

31 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-161, хуудас 57

32 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-87, хуудас 3

33 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-161, хуудас 58

байшин, Туул голын дагуу хээрийн судалгаа хийв. Монголчуудын дунд буй үлгэр, домог зэргийг тэмдэглэхийн зэрэгцээ хуучны бичиг дурсгалыг үзэж судалжээ.<sup>34</sup> Н.Н.Поппегийн дурдатгалд, “Эхлээд бид Чин толгой хэмээх Хятаны хэрэм байсан, хүний гараар бүтээсэн зуугаад фут өндөр овоон дээр ирлээ. Тэнд бид яст мэлхийн хэлбэр бүхий дурсгалын зөвхөн суурийг хэсгийг олсон бөгөөд яг бичигтэй хэсэг нь байхгүй байв..... Чин толгойгоос бид Монголын тусгаар тогтнолын төлөө тэмцэгч алдарт Цогт тайжийн XVII зуунд Туул голын хөвөөнд босгосон Цагаан байшин хэмээх балгас дээр очив. Тэндээс олдсон бичээсийг Георг Хүт герман орчуулгын хамт 1894 онд хэвлүүлсэн билээ. Бид өөр бичиг хайсны дүнд Цогт тайжтай холбогдох, цүүцээр сийлсэн, 1627 нэгэн хадны бичээс олсон юм” хэмээн бичжээ.<sup>35</sup> Н.Н.Поппе, Б.Б.Бамбаев нар Цогтын Цагаан байшингаас Хар балгасаар дайран Эрдэнэзуу хийд рүү очжээ. Тэд Эрдэнэзуу хийдэд буддын шашны цам хэмээх гайхамшигт баг бүхий жүжигчилсэн тоглолтыг анх удаа үзжээ. Цамын тухай, “Монголчууд сүсэгтнүүд цамыг ямар нэгэн ид шидэт, бурханлаг үйл гэж ойлгосны улмаас түүнд сүсэглэн залбирч, бүр агнуулж буй буга болон бусад амьтныг дүрслэх жүжигчдээс хүртэл адис авч, багт нь хүрч байв” гэсэн байдаг.<sup>36</sup>

1926 онд хамгийн урт замыг туулж, судалгаа хийсэн отряд бол Н.В.Павловын удирдсан ботаникийн отряд байв. Энэ отрядад ботаникч Н.П.Иконников, Галицкий, Я.И.Проханов нар ажилласан байна. Отряд хоёр хэсэг болон хуваагдаж, нэгдүгээр баг Улаанбаатараас гарч, Цэцэрлэг, Эгийн даваа, Жавхлант [Улиастай] хот Хатгал, Мондын чиглэлд явсан бол хоёрдугаар анги нь Алтанбулаг, Цэцэрлэг, Орхоны эх, Эрдэнэзуу, Улаанбаатар гэсэн чиглэлд судалгаа хийжээ. Нэгдүгээр анги Цэцэрлэгээс Хатгал хүртэл газрын зургийг үйлдэж, хангай газрын ургамлыг ерөнхий газарзүйтэй харьцуулан нэн нягт тодорхой судалгаа хийжээ.<sup>37</sup>

1926 онд шинээр Монголд ирсэн зоологийн судалгааны ангийг А.Н.Кириченко удирдан, А.Я.Тугаринов, А.А.Формозов нарын гурван зоологич Улаанбаатар, Ламын гэгээн, Их Богд, Жавхлант [Улиастай], Хатгал, Мондын чиглэлд явжээ. Тус отряд Монгол орны амьтны маш баялаг цуглуулга хийжээ.<sup>38</sup> Гидрохимийн отрядыг А.М.Смирнов удирдан явуулж, Улаанбаатар, Улиастай, Улаанбаатар чиглэлд ажиллаж нийт 55 рашааныг судлав.<sup>39</sup> 1923 оноос эхэлсэн геологийн судалгааны отряд Баруун Монголд явуулж буй судалгаагаа үргэлжлүүлэн явуулж, судалгааны үр дүнгээ нэгтгэн “Монгол-Алтайн нурууны салбар Баатар хайрхан уул” хэмээх өгүүллийг хожим хэвлэсэн байна.

1927 оноос Монголын комиссын зохион байгуулалтыг өөрчлөн үйл ажиллагааны хамрах хүрээг нэмэгдүүлэв. Комиссын үндсэн судалгаа БНМАУ болон БН Тагна

34 Т.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. Стр. 92

35 Николас Поппе. Дуртгал. Орчуулагч М.Саруул-Эрдэнэ. УБ., 2008. Тал 77-78

36 Николас Поппе. Дуртгал. Орчуулагч М.Саруул-Эрдэнэ. УБ., 2008. Тал 79

37 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-161, хуудас 59

38 Т.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. Стр. 93

39 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-87, хуудас 3

Тува Ард улсад явуулж байсан дээр Буриад-Монголын автономит мужийг нэмэн оруулав. Ингэснээр Монгол, Тува, Буриад-Монголыг судлах комисс гэж нэрлэх болжээ.

Үүнээс гадна тус онд ЗХУ-ын Ардын Комиссариатын Зөвлөлийн газрын дэргэд байсан тус комиссыг Оросын ШУА руу шилжүүлсэн байна.<sup>40</sup> Комиссыг ШУА-ийн дэргэд шилжүүлсний дараа даргаар нь академич С.Ф.Ольденбург, түүний орлогчид академич А.Е.Ферсман (1927 оны 9 дүгээр сараас академич П.П.Сушкин), эрдэмтэн нарийн бичгийн даргад В.И.Крыжановскийг сонгожээ. Комиссын бүрэлдэхүүнд академич В.В.Бартолд, В.Л.Комаров, Н.Я.Марр, П.П.Сушкин, Г.И.Боровка, Б.Я.Владимирцов, В.А.Обручев, Б.Б.Полынов, И.Пачковский, С.И.Руденко, С.А.Теплоухов, Ю.М.Шокальский, П.К.Козлов, Н.П.Горбунов, Ф.Н.Петров нар багтсан байна.<sup>41</sup>

Зохион байгуулалтаа шинэчилсэн Монголын комисс 1927 онд өмнө нь явуулж байсан экспедицийн ажлыг үргэлжлүүлсний дээр шинээр бас хэдэн отрядыг явуулжээ.

Баруун Монголын геологийн судалгааг 1923 оноос хойш тасралтгүй хийсэн И.П.Рачковскийн баг 1927 онд дахин ажилласан байна. И.П.Рачковскийн Судар бичгийн хүрээлэнд өгсөн товч тайланд “Жавхлант [Улиастай] хотоос баруун тийш гарч Хасагт хайрхан уул, Хан Тайшир уулын Шаргын говь, Алтайн нурууны Цаст Богд, Хар-Ус хэмээх нуур, Бөх мөрөн ба Хар-Усаас умарт чиглэлд явж уулсыг шинжсэн нь ерөнхий геологийн ба тектоникийн (газрыг хэрхэн дэнслэн хөдөлж тогтсоны байдал) зэрэг чухал зүйлүүдийг шинжин мэдсэн тул Баруун Монголын газар орны геологийн байдал эдүгээ төлөв илэрхий болсон тул шинжсэн зүйлээс дээр чухал болгон ашиглахад бэлхэн буй нь. Жаргалант Орог нуурын тэрэгний замд Засагт ханы хүрээний орчим Далх (Лхачин) чулуу нэн элбэг бүхий газар буй чулууны байдлыг шинжвээс Дайчин вангийн хүрээний орчим мөн Далх байж болох мэт буй. Хархираа уулсын орчим Бургастай голоор сайн чулуу нүүрс их зузаан элбэг бүхий газар буй бөгөөд энэ нь хойч өдөр Ховд, Улаангомд хэрэглэж болох болой” хэмээн бичсэн байна.<sup>42</sup> Геологийн судалгааны баг 1927 онд хоёр хуваагдан явсны нөгөөг нь З.А.Лебедева ахлан Тагна Тувагийн нутагт судалгаа хийжээ.

Угсаа-хэл шинжлэлийн отряд гурав дахь удаагаа ирэв. Энэ удаа Н.Н.Поппе хоёр дахь удаагаа отрядыг удирдан ажиллажээ. Түүний судалгааны багт В.А.Казакевич, С.Д.Санжеев, Б.Б.Бамбаев нар багтжээ. Н.Н.Поппе Улаанбаатар хотод төвлөн нутгийн аялгуу судалснаас гадна Улаанбаатараас Орхоны чиглэлд явж аман зохиолын эх хэрэглэгдхүүн цуглуулжээ. Улаанбаатар хотод Барга-Буриад, Өвөр Монголын Харчин, Ордос, Улаанцавын аялгаар ярьдаг хүмүүсийг олж судалжээ. Дараагаар нь Хараа голын эх Хүйн гол хүрч, Хэнтий нуруунаас эх авах Түнхэлийн голд хүрч, тэндээсээ доод Орхон, Амарбаясгалант хийдэд хүрч аман зохиолын

40 Т.И.Юсупова. Международные научные отношения «нового типа»: советско-монгольское научное сотрудничество, 1920-1930-е гг. //MONGOLICA-XX. СПб. 2018. Стр. 32

41 Т.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. Стр. 96

42 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-161, хуудас 59

материал цуглуулжээ.<sup>43</sup> В.А.Казакевич Дарьгангаар явж, түүний үүсэл, угсаатны бүрэлдэхүүн, байгаль цаг уур, байр зүй, нутгийн захиргаа, түүний онцлог, түүх, соёлын дурсгалууд зэргийг судалсан байна. Тэрээр Дарьгангад ажилласан хээрийн судалгааны тайлан дээр үндэслэн “Дарьганга дахь булшин дээрх хүн чулуун хөргүүд”<sup>44</sup> хэмээх бүтээлийг “Монголын комисс”-ын цувралд хэвлүүлсэн байна. Энэхүү бүтээл нь монголын хүн чулууны судалгаа болон Дарьганга судлалын анхны томоохон бүтээл болжээ.

Б.Б.Бамбаев Улаанбаатар хот, Мишиг гүн, Цэцэрлэг, Тариат, Намнан уул, Вангийн хүрээ, Улаанбаатар хот гэсэн чиглэлд явж, замын гудас булш бунхны зүйлийг шинжин үзсэн бөгөөд товч илтгэл план зураг ба гэрэл зургуудыг авчээ.<sup>45</sup> Харин С.Д.Санжеевын маршрут нь Алтанбулагаас Сэлэнгэ мөрний нэг эх Эгийн гол хүрээд, тэндээсээ Хатгал, Хатгалаас Дархадын [Зөөлөнгийн] хүрээнд хүрч ажиллаад буцаж Хатгал ороод, усан онгоцонд сууж Ханх хүрээд, Оросын хил рүү орж, Түнхэн хүрээд, Байгал нуур гэж явжээ. Түүний судалгаа нь Дархадын түүх, овгийн бүрэлдэхүүн, хэлний онцлог, бөөгийн ёс заншил, дархадын дундах бурхны шашин, мал аж ахуй зэргийг судалсан байна.<sup>46</sup>

1925 онд анх төлөвлөж байсан угсаатны зүйн отрядыг Л.А.Амстердамская тэргүүлэн 1927 онд явжээ. Улаанбаатараас зүүншээ Өндөрхааны чиглэлд явж, монголчуудын идээ ундааны зүйл, арьс шир боловсруулах арга технологи, үлгэр домог зэргийг судалсан байна.<sup>47</sup> Хожим 1940 онд “Халхын зүүн нутгийн ардын үлгэр” хэмээх бүтээлийг нийтлүүлжээ.

Хөрс, газарзүйн отрядыг Н.Н.Лебедев удирдсан байна. Улаанбаатар хот Сэцэн ханы хүрээ [Өндөрхан], Дарьганга (Чойроор өнгөрөн) Сайр-Ус, Улаанбаатар хот гэсэн чиглэлд явжээ. Судалгааны баг газрын хөрс ба ургамлын зүйлийг нягтлан шинжиж, гербари [ургамлын хатаадас] ба газар хөрсийн дээжийн цуглуулга хийж, цуглуулгын заримыг Судар бичгийн хүрээлэнгийн музейд шилжүүлсэн өгчээ. Энэ отрядад багтсан О.Н.Михайловская Улаанбаатар хот, Төхөм нуур, Эрдэнэ зуу, Орхоны эх, Сайн ноён, Мишиг гүн, Улаанбаатар хот гэсэн чиглэлд явж, газрын газар хөрс ба ургамлын зүйлээс газар хөрс ба ботаникийн цуглуулга хийж, зорчсон газрын маршрутыг үйлдсэн<sup>48</sup> байдаг.

Судар бичгийн хүрээлэнгээс Монголын комиссын үйл ажиллагааг тогтмол дэмжихийн зэрэгцээ, зарим хээрийн судалгааны ажлыг санхүүгийн хувьд бүрэн хариуцан явуулж байв. Жишээлбэл, 1927 онд эрдэс судлаач В.А.Смирновтой

43 Николас Поппе. Дуртгал. Орчуулагч М.Саруул-Эрдэнэ. УБ., 2008. Тал 83-84

44 В.А.Казакевич. Намогильные статуя в Дариганге. Поездка в Даригангу. Материалы комиссии по исследованию Монгольской и Танну-Тувинской Народных республик и Бурят-Монгольской АССР. Выпуск 5. Издательство Академии наук СССР. Л, 1930. Стр. 1-62

45 МУУТА. ТБА. X-23, Д-1, ХН-161, хуудас 59.

46 Г.Д.Санжеев. Дархаты. Этнографический отчет о поездке в Монголию в 1927 году. Материалы комиссии по исследованию Монгольской и Танну-Тувинской Народных республик и Бурят-Монгольской АССР. Выпуск 10. Издательство Академии наук СССР. Л, 1930. Стр. 1

47 МУУТА. ТБА. X-23, Д-1, ХН-161, хуудас 59.

48 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Т. 100

Германд сурч байсан сурагч Бат-Очирыг дагалдуулан Хан Хэнтий уулын аймгийн Баянтүмэн уулын хошууны нутагт рашаан ус болон эрдэс баялгийг судлуулахаар явуулж байжээ. Судалгааны зардалд В.А.Смирновт 300 төгрөг, оюутан Бат-Очирт 100 төгрөгийг Судар бичгийн хүрээлэнгээс олгож байжээ.<sup>49</sup> Энэ хоёр нийт 11 халуун, хүйтэн рашааныг судлан химийн найрлагыг тогтоосон байна<sup>50</sup>. Эдгээр рашаануудын дээжийг шинжлэн үзсэний үндсэн дээр хоёр ялгаатай бүлэгт хуваагдаж байгааг тодорхойлжээ. Нэгдүгээрт, галт уулын чулуулагтай өндөр уулын бүсд байдаг их халуун, цацраг идэвхт хий гаргадаг онцлогтой рашаанууд. Нөгөө нь монголын нам дор газар тунадас ба хувирмал чулуулагтай, мөнх цэвдгийн нөлөөлөлтэй рашаанууд. Энэ хэсгийн рашаанууд нь нүүрс хүчил ихтэй, нүүрс хүчлийн шохойн ундаргын хэв маягт хамаарагдахыг илрүүлжээ<sup>51</sup>.

Тус комисс нь Тагна Тува, Буриад-Монголыг багтаах болсон учир 1927 онд И.П.Рачковскийн удирдсан геологийн отрядын нэг салбар З.А.Лебедева, геохимийн К.Л.Островскийн удирдсан отряд, археологийн С.А.Теплоухов нарын отрядууд Тагна Тувад ажилласан байна.

1928 оны 5 дугаар сарын 10-нд тус комиссын ээлжит хуралдаан болж, П.К.Козловын малтсан нойтон булшны тухай асуудлыг Археологи, технологийн хүрээлэн дээр хэлэлцжээ. Тус хуралд Г.И.Боровка Судар бичгийн хүрээлэнгээс Ноён уулын олдворын эхний хэсгийг гэрээний дагуу шилжүүлсэн гэдгийг танилцуулсан байна. Үүнээс гадна Е.В.Козловагийн зоологийн отрядын 1928-1929 оны төлөвлөгөөг баталж, Монголд ажилласан зарим отрядуудын урьдчилсан тайланг хэлэлцэв. Харин 1928 оны 5 дугаар сарын 20-нд болсон Монголын комиссын дараагийн хурлаар С.И.Руденкогийн антропологийн отряд, Б.Я.Владимирцовын угсаа-хэл шинжлэлийн отряд, И.П.Рачковскийн геологийн отряд, Н.П.Иконниковын ботаникийн отряд, В.А.Смирновын эрдэс судлалын отряд, А.Я.Тугариновын зоологийн отряд<sup>52</sup> зэргийг хээрийн судалгаанд явуулах төлөвлөгөө болон санхүүгийн тооцоог хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Геологийн судалгаа (Тагна Тува)	5000 рубль
- Ботаникийн судалгаа (Монгол)	5000 рубль
- Зоологийн судалгаа (Монгол)	10000 рубль
- Угсаа-хэл шинжлэлийн судалгаа (Буриад-Монгол)	1500 рубль
- Хэл шинжлэлийн судалгаа (Буриад-Монгол)	1500 рубль
- Хоёр антропологичийн томилолт (Буриад-Монгол)	1500 рубль
- М.И.Тубянскийн судалгааг үргэлжлүүлэхэд	500 рубль
- Монгол дахь хөрсний судалгаа	4000 рубль
- Газрын зураг бүтээхэд	5000 рубль
- Ном хэвлүүлэхэд	14000 рубль

49 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-112, хуудас 2-11

50 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-163, хуудас 4

51 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть

1. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Тал 77

52 СПФ АРАН. ф.339, оп.1, д.1, л. 14-17

- Зохион байгуулалтын зардал 500 рубль<sup>53</sup>-ийг тус тус баталжээ.

Комиссын дарга С.Ф.Ольденбургаас Монголын говийг судлах иж бүрэн судалгааг эхлүүлэх саналыг оруулж, үүнд 25000 рублийг төсөвлөн явуулах талаар санал оруулсан байна. Түүний саналыг энэ удаа хойшлуулжээ. Тиймээс 1928 онд Монголын комиссоос зоологи, ботаник, хөрс судлалын гурван экспедиц ажилласан байна.

Судар бичгийн хүрээлэнгээс БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр байгаа ашигт малтмал, эрдэнийн чулуу, рашаан усыг судлуулах сонирхолтой байсан учраас химич В.А.Смирновын судалгааг нэлээд дэмжиж байв. Тиймээс түүний хээрийн судалгааны санхүүжилтийг 1928 онд дахин гаргасан байна. Монголын комиссоос В.А.Смирновыг хөрс судлаач Н.Н.Лебедевын хамтаар Судар бичгийн хүрээлэнгийн мэдэлд томилж явуулахаар шийдвэрлэсэн байна. В.А.Смирнов өөрийн отрядад Н.Н.Лебедевээс гадна байрзүйч С.С.Рузов, дагалдах оюутан Л.П.Шастин, ажилчин, жолооч нарыг багтаагаад нийт зардалд 9998 рубль зарцуулах бөгөөд замын маршрут нь:

1. Хүрээ (Улаанбаатар)-Баян-Бэлчих... Үйзэн, Сайр-Ус, Үүд (Замын-Үүд) 860 мод
2. Үүд, Сайн, Хөтөл, Шавартай, Говь, Егүзэр.... 550 мод
3. Егүзэр, Нүхтийн даваа, Батхаан.... 380 мод
4. Батхаан, Хүрээ 700 .... мод

Нийт 2500 орчим мод газрыг туулахаар төлөвлөжээ.<sup>54</sup>

В.А.Смирновын отряд төлөвлөсөн ёсоор Улаанбаатарт ирж судалгааны ажлаа явуулжээ. Тэд уулын чулуулаг, хөрс, ургамал, худгийн усны анализ зэргийг судалгаа хийсэн юм. Ялангуяа В.А.Смирнов Дарьгангын бүсэд хүдэр болон олборлож болох өөр ашигт малтмалыг судлан үзээд маш баялаг гарцтай гантиг, гялтгана, төмөр ба зэсийн хүдрийг илрүүлснээс гадна Егүзэрийн хүрээний орчмоос чулуун нүүрс, Хараатын орчмоос соронзон төмрийн ордыг илрүүлжээ. Замын дагуух худгуудыг шинжлэн үзэхэд нэг метр квадрат газрын хөрсөн дээрх ууршилт зундаа 7-13 литр, намар 3-4 литр байна гэж тогтоожээ<sup>55</sup>. Ялангуяа говийн хүн амд цэнгэг ус маш их хэрэгтэй байгааг тодруулсан нь энэ удаагийн хээрийн судалгааны гол үр дүн байв.<sup>56</sup>

А.Я.Тугариновын удирдсан зоологийн отряд “Улаанбаатар хот, Замын Үүд, Улаанбаатар хот, Сэцэн хан, Баян төхөм, Буйр нуур, Халхын гол, Баян төхөм чиглэлд явж, газарзүйн ерөнхий байдал ба адгуусан аймгийн зүйл, ургамлын аймгаас бага сага шинжин үзсэнээс гадна, Халхын голд ус чийг элбэг, газар шороо сайн ургамлын зүйл баялаг тул хойч өдөр хөгжин Монголын аж ахуйн чухал гол газар болж чадмуй” хэмээн дүгнэсэн байна.<sup>57</sup>

53 СПФ АРАН. ф.339, оп.1, д.1, л.8-10

54 Жамсрангийн Цэвээн. Түүвэр зохиолууд. Эмхтгэсэн С.Идшинноров. 1997. Т. 180-181, 187-188.

55 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-163, хуудас 5

56 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть 1. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Тал 77

57 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-161, хуудас 60

Харин О.Н.Михайловскаягийн удирдсан хөрсний отряд Улаанбаатар хот, Сөгнөгөр, Туул, Орхон, Хангал, Сэлэнгэ, Ивцэг гол, Орхон, Хараагийн адаг Ерөөгийн адаг, Шаамар, Алтанбулаг чиглэлд явжээ. Замын дагуу 1 см-т 5 км бүхий масштабаар газрын зураг үйлдсэн ба геологи, ботаникийн цуглуулга хийжээ. Газрын зурагт явсан замын дагуу дэд өндөр, дунд өндөр, өндөр хээр тал ба элсэн газрын байдлыг тэмдэглэн ботаникийн талаар шинжин үзжээ.<sup>58</sup> Тус отрядын ахлагч О.Н.Михайловскаягийн урьдчилсан тайланд, “Дорнод Монголын газар нутгийг судалж, хүрэн өнгөт хөрсний бүрээс, хар хүрэн өнгөтэй хөрсний бүсд шилжих шилжилтийн хязгаар, төлөв байдлыг судалж, Монголын цөл тал, хээрийн бүсийн мөн чанар нь болсон хөрсний бүрдлийг илрүүлэн гаргаснаар бидний өмнө тавигдсан зорилт биелэгдсэн гэж үзэж байна. Дорнод Монголын элс тархсан уудам талбайтай, хүрмэн чулуун гадаргатай, ямар ч өвс ургамалгүй, заримдаа бүр эсэргээр гайхам өтгөн өвс ногоотой байх нь цөлийн бүсийн нөхцөлд хамгийн их хачирхал төрүүлж байв. Жинхэнэ “цөл говь” нь Хэнтийн ой хөвчийн нэгэн адил судалгаагаа хүлээж байна” хэмээн дүгнэжээ.<sup>59</sup> Түүний тайлангаас Дорнод Монголд явуулсан хөрсний судалгаа нь ямар үр дүнтэй ажилсныг харж болно.

1928 онд Монголын комиссоос Монголд явуулсан хээрийн судалгаанууд дууссаны дараа мөн оны 10 дугаар сарын 22-нд Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Ж.Цэвээн Монголын комиссын дарга С.Ф.Ольденбургт нэлээд өргөн агуулгатай захиа явуулжээ. Захианы утга нь, Оросын ШУА (Монголын комисс)-иас Монголд явуулж байгаа судалгааны ажлуудад сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлжээ. Үүнээс гадна Судар бичгийн хүрээлэн, ШУА хоёрын хоорондын харилцааг улам ойртуулах, Монголд чулуугаар барьсан зориулалтын музей, номын санг байгуулахад ШУА-иас тусламж үзүүлэхийг хүсчээ. Үүнээс гадна Судар бичгийн хүрээлэнгийн хүсэлтээр судалгаа хийж буй Оросын эрдэмтэд В.А.Смирнов, Б.Б.Полынов нарын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэхийн дээр М.И.Тубянскийн Монголд ажиллах хугацаа дуусаж байгаа тул түүний хугацааг сунгах зэрэг асуудлыг хөндсөн байна.<sup>60</sup> Үүнээс гадна тус хоёр газар хамтран “Монгол угсаатны нутгийн аялгууг судлах, Ардын аман зохиол”-ыг хэвлэх ба энэ ажлыг эхлүүлэн ШУА-ийн хаягаар 1000 рубль шилжүүлсэн байна.<sup>61</sup>

1929 оны эхэнд шинжлэх ухааны ажлыг төлөвлөх кампанит ажил өрнөжээ. Тухайлбал, 1929 оны 4 дүгээр сарын сүүлээр Оросын ШУА-ийн өргөтгөсөн хуралдаанаар ШУА, түүний харьяа хүрээлэнгүүдийн шинжлэх ухааны үйл ажиллагааг 5 жилийн төлөвлөгөөгөөр эхлүүлэх асуудлыг оруулсан байна. Энэ нь Шинжлэх Ухааны Академийн үйл ажиллагааг “ЗХУ-ын үндэсний эдийн засгийг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө (1928-1932)-тэй холбогдуулан шийдвэрлэсэн байна. Тийм учраас Оросын ШУА-ийн дэргэд шилжсэн “Монголын комисс”-оос

58 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-163, хуудас 5

59 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть

1. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Тал 64-65

60 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-145, хуудас 46-48

61 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-145, хуудас 46-48

явуулах судалгааны ажлаа таван жилээр төлөвлөж, түүнийгээ БНМАУ-ын Судар бичгийн хүрээлэнтэй зөвшилцөн явуулах шаардлага тулгарчээ. Монгол руу явуулах отрядуудыг гаргахын урьд шинжлэх ухааны чиглэл бүрээр цаашид таван жилийн хугацааны төлөвлөгөөг боловсруулах ажлыг хийжээ. Жишээлбэл Баруун Монголд 5 жил орчим судалгаа хийсэн И.П.Рачковскийн геологийн судалгааны баг Монгол Алтайн нуруунаас зүүншилж Хангай нурууны геологийн тогтцын судалгааг эхлүүлж, таван жилийн хугацаанд явуулахаар төлөвлөсөн байна. Тус төлөвлөгөөнд судалгааны ажлын бүрэлдэхүүн, зарцуулах мөнгөний тооцоо зэргийг нарийн тусгажээ. Үүнд, хээрийн ба суурин судалгаа явуулахад бүгд 210000 рубль зарцуулахаар төлөвлөжээ.<sup>62</sup> Геологийн отрядаас гадна бусад судалгааны отрядууд бүгд өөрийн төлөвлөгөөг боловсруулсан байна.

Ж.Цэвээний захиа болон Оросын ШУА-ийн олон хүрээлэнгүүдийн таван жилийн төлөвлөгөөтэй холбоотойгоор “Монголын комисс”-оос Монголд явуулж буй үйл ажиллагааг тодорхой болгох, Судар бичгийн хүрээлэнтэй нягт хамтран ажиллах хэрэгтэй болов. Тиймээс 1929 онд Монголд ажиллах отрядуудын талаар “Монголын комисс” болон Судар бичгийн хүрээлэнгийн хооронд ямар ямар экспедицүүдийг ажиллуулах талаар гэрээ байгуулахаар болжээ.

1929 онд Монголд ажиллах “Монголын комисс”-ын отрядууд юуны урьд Судар бичгийн хүрээлэнтэй харилцан тохиролцсон гэрээг Улаанбаатар хотноо мөн оны 5 дугаар сарын 24-нд байгуулжээ. Тус гэрээ нь нийт 8 зүйлтэй бөгөөд Судар бичгийн хүрээлэнг төлөөлж, дарга С.Жамьян, гишүүн Ц.Бат-Очир, Оросын ШУА-ийг төлөөлж Е.Козлова нар гарын үсэг зуржээ. Гэрээнд Оросын ШУА-иас ирэх 3 экспедиц нь Монгол улсын хууль дүрмийн дагуу ажиллах бөгөөд ялангуяа 1924 оны хуучны зүйлийг сахих хамгаалах дүрмийг баримтлах, судалгааны ажлын хүрээнд цуглуулсан материалуудыг Судар бичгийн хүрээлэнд танилцуулж, нэг хэсгийг нь тус хүрээлэнгийн дэргэдэх Үндэсний музей, номын санд үлдээх ба үлдсэн материалыг нь түр ашиглуулах зорилгоор ШУА-д өгч болох бөгөөд өөр ямар нэгэн байгууллагад шилжүүлэхийг хориглох, материалыг боловсруулах хугацаа нь дууссан бол Судар бичгийн хүрээлэнд шилжүүлнэ. Шинжилгээний анги Судар бичгийн хүрээлэнд товч тайлан, холбогдох зургийн нэг хувийг мөн хүрээлэнд үлдээх, шинжилгээний явцад бүтээсэн боловч хэвлээгүй газрын зургийн нэг хувийг, мөн шинжилгээний ангийн бүтээлийг хэвлүүлсэн бол 50 ширхгийг Судар бичгийн хүрээлэнд өгөхөөр заажээ.

Гэрээнд зөвхөн БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ажиллах Н.П.Иконников-Галицкийн удирдсан ботаникийн отряд, Е.В.Козловагийн удирдсан зоологийн отряд, Н.Н.Поппегийн удирдсан угсаа-хэл шинжлэлийн отрядуудыг тусгасан байна. С.А.Теплоховын археологийн экспедиц, З.А.Лебедевагийн геологийн экспедицүүд нь Тагна-Тувад ажилласан учир үүнийг гэрээнд тусгаагүй ажээ.

Е.В.Козлова Судар бичгийн хүрээлэнтэй гэрээ байгуулаад Улаанбаатар хотоос гарч Улиастай хүрээд, тэндээсээ үхэр тэргээр Ширээ голыг өгсөн Буян голын

<sup>62</sup> Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть 1. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Тал 75-76

хөндийг гатлан Отгон тэнгэр уулын мөнх цаст оргил рүү өмнө талаас нь хүрчээ. Тэнд 20 орчим хоног уулын нугын орчимд ажиглалт судалгаа явуулж, Отгонтэнгэрээс зүүн хойд зүг чиглэн явж, Тарвагатайн нуруунд хэсэг саатан, Тэгш хэмээх рашаан дээр түр ажиглалт судалгаа хийгээд Хөвсгөл нуурыг чиглэн явжээ. Хөвсгөл нуураас Монд боомтоор Оросын хил рүү орсноор судалгааны ажлаа өндөрлөсөн байна. Отгонтэнгэр уулаас зүүн хойд чигт явахдаа Шумуултай, Идэр гол, Сангийн далай нуур, Мөрөнгийн хүрээ, Эрхэл нуураар дайран Хөвсгөл нуур хүрсэн байна.<sup>63</sup>

Отрядын судалгааны үр дүнд Хангайн нурууны амьтны аймаг нь өндөр уулын цармын бүрэлдэхүүнтэй ямар холбоотойг бүрэн дүүрэн хариулж чадахуйц болжээ. Хангайн нуруу нь Төв Азийн өндөр уулын тайга болон Дорнод Соёны нурууны бүслүүрт хамаарагдах хэв шинжтэй байв. Цуглуулгын 52 дугаарт бүртгэгдсэн зангалай шувуу нь амьтны аймгийн газрын зурагт шинээр дүрслэгдэх болсон. Өгөөлэй шулганаа хэмээх шувууны маш ховор төрлийг олж, экологийн амьдрах нөхцлийг нь тодорхой болгов. Урьд нь энэ төрлийн шувууны тархац нутгийн хойд зах нь Говь-Алтайн бүс нутагт байдаг гэдгийг өөрчилж Улиастайн өмнө талын Ширээгийн голын дагуух хадаар үүр, өндөг, ангаахай нь байсныг олж илрүүлснээр тодорхой болгосон юм.

Хөхтөн амьтны хувьд Отгонтэнгэрийн өндөр уулын бүсээс үнэгний сонирхолтой хэв маяг, гүег зэргийг олсон бол амьтны аймгийн газрын зураг дээр шинээр Тарвагатайн нуруунаас олдсон үхэр оготныг дүрслэхээр болжээ. Урьд нь энэ үхэр оготныг зөвхөн Хэнтий нуруунд байдаг хэмээн үздэг байв. Энэ удаагийн судалгаагаар нийт 117 зүйлийн 508 ширхэг шувуу, 16 зүйлийн 100 ширхэг хөхтөн амьтны цуглуулга болон Отгонтэнгэр орчмын өндөр уулын бүсийн ургамлын цуглуулга хийжээ. Улиастайгаас Хөвсгөл нуур хүртэл 750 км аялал хийхдээ цаг уурын ажиглалтыг хийсэн байна.<sup>64</sup>

Н.Н.Иконников-Галицкийн удирдсан ботаникийн отрядад В.А.Иконникова-Галицкая судлаачаар ажилласан байна. Тэд өмнөх жилийн Хэнтийн нурууны уулын бүсэд хийсэн судалгаагаа үргэлжлүүлжээ. Судалгааны үр дүнд, Хэнтийн нуруу нь Явлааны нурууны шууд үргэлжлэл ба Номхон далай, Хойд мөсөн далайд цутгах голын ай сав бөгөөд Хэрлэн, Онон, Туул, Минж, Ерөө зэрэг таван голын эх авдаг газар болохыг тодорхойлов. Хэнтий нурууны ойн үндсэн бүрэлдэхүүнийг шинсэн ой эзлэх ба Туул голын сав дагуу хушин ой, Ерөө голын сав дагуу нарсан ой зонхилж байсан бол Минж голын дагуу хусан ойн төгөлүүд нэлээд байгааг тэмдэглэсэн байна. Үүнээс гадна Хэнтий нурууны ой нь араараа хөгжсөн бол, өвөр нь сул хөгжсөн байжээ. Хэнтий нурууны уулсын царам нь үндсэн хоёр хэлбэрт хуваагдсан байна. Нэгдүгээрт, чулуурхаг нүцгэн оройтой, ширэгжээгүй шовх, бөмбөгөр оргилтой уулс. Энэ төрөлд, Оюут, Асралт хайрхан зэрэг уулс хамаарагдана. Хоёрдугаарт альпийн нуга, намагтай, зүүн, зүүн өмнө талаараа нугатай уулс орно. Энэ төрөлд Хэрхлүүр, Туул голын эхний уулс хамаарагдана<sup>65</sup>.

63 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-165, хуудас 3

64 Мөн тэнд.

65 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-165, хуудас 2

Н.Н.Поппегийн удирдсан угсаа-хэл шинжлэлийн отряд 1929 онд дөрөв дахь удаагаа Монголд ирж ажиллажээ. Энэ удаа Н.Н.Поппе зөвхөн Улаанбаатар хотод ажиллаж Солон, Барга, Ордос болон Урад аялгууг үргэлжлүүлэн судалжээ. Түүний дурдатгалд, “Эдгээр аялгаар голчлон Өвөр Монголд хэлэлцдэг боловч тухайн үед Улаанбаатарт бас олон тийм аялгуутан ажиллаж, амьдарч байсан юм. Хэлийг нь судалж буй хүмүүстэйгээ ажилласныхаа дараа би хотоос гарч, үзэсгэлэнт шигүү ойгоор нь явав” хэмээн бичжээ.<sup>66</sup> Цуглуулсан баримтууд дээрээ тулгуурлан Н.Н.Поппе 1931 онд “Солон хэлний материалууд” хэмээх бүтээлээ нийтлүүлжээ.

Оросын ШУА, түүний дэргэдэх “Монголын комисс”-оос Монголд явуулах ажлын таван жилийн төлөвлөгөөг БНМАУ-ын Засгийн газар болон Судар бичгийн хүрээлэнтэй харилцан тохиролцохоор болжээ. Баруун Монголд олон жилийн судалгаа хийсэн Оросын ШУА-ийн Геологийн музейн ажилтан профессор И.П.Рачковский Монголын комиссыг төлөөлөн гэрээ байгуулахаар Улаанбаатарт 1929 оны намар хүрэлцэн иржээ. Энэхүү таван жилийн төлөвлөгөөг хэлэлцэхээр Судар бичгийн хүрээлэн, Ардыг гэгээрүүлэх яам, Эдийн засгийн зөвлөлийн тэргүүлэгчид хамтран хуралджээ. И.П.Рачковский таван жилийн төлөвлөгөөг уншиж танилцуулсан байна. Түүний илтгэснийг сонсоод өргөтгөсөн хурлаас, төлөвлөгөөг ерөнхийд нь зөвшөөрч баталжээ. Гэхдээ хэд хэдэн чиглэлийг нэмэх санал оруулсан байна. Үүнд, хүн ам, малын эрүүл мэндийг судлах, аж ахуйн хөгжилт ба ангийн ялгарлын байдлыг судлах, мал аж ахуй, тариалангийн тохиромжтой бүс нутгийг судлах, шарын шашин сүм хийдийн аж ахуй, эдийн засгийг судлах, эрдэм шинжилгээ судалгааны туршилтын станцуудыг байгуулах, хүн амын өсөлтийг судлах саналуудыг оруулжээ.<sup>67</sup> Эцэст нь, эдгээр эрдэм шинжилгээний ажлын тодорхой үр дүнгүүдийг амьдрал дээр хэрэгжүүлэх дүгнэлтийг хийж байгаасай хэмээн хүссэн байна.

Төлөвлөгөө нэгэнт Монголын албан ёсны газруудаар зөвшөөрөгдсөн тул Монголын комиссыг төлөөлж И.П.Рачковский, Судар бичгийн хүрээлэнгийн дарга С.Жамьян, гишүүн Ж.Цэвээн нартай харилцан тохиролцож дээрх төлөвлөгөөний дагуу гэрээнд гарын үсэг зурсан юм. И.П.Рачковскийн авчирсан төсөл хэвээр батлагдсан бөгөөд Монголын талаас санал оруулсан зүйлс тусгагдаагүй байна. Гэрээний үндсэн агуулга нь Оросын ШУА-иас 1930-1934 онд Монголд ажиллуулах экспедицүүдийг явуулах, үүнд Судар бичгийн хүрээлэн ямар үүрэг оролцоотой оролцох тухай заасан байна. Дээрх хугацаанд явахаар батлагдсан экспедицүүдийг нэрлэвэл:

1. И.П.Рачковскийн геологийн экспедиц
2. В.М.Кобланскийн геохимийн экспедиц
3. А.А.Борисякийн палеонтологийн экспедиц
4. В.А.Смирновын гидрогеологийн экспедиц
5. Б.Б.Полыновын хөрсний экспедиц
6. В.М.Комаровын ботаникийн экспедиц

<sup>66</sup> Николас Поппе. Дуртгал. Орчуулагч М.Саруул-Эрдэнэ. УБ., 2008. Тал 88

<sup>67</sup> МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-136, хуудас 5-6

7. А.Я.Тугариновын зоологийн экспедиц
8. С.А.Теплоуховын палео-этнологийн экспедиц
9. Г.И.Боровкагийн археологийн экспедиц
10. С.И.Руденкогийн антропологийн экспедиц
11. Б.Я.Владимирцовын угсаа-хэл шинжлэлийн экспедиц

зэрэг эдгээр 11 төрлийн экспедицүүд багтсан байна. Үүнээс гадна гэрээнд, эдгээр экспедицүүдийг хаагуур явуулах, олсон олдвор хэрэглэгдэхүүнийг хэрхэн судлуулах, хэний өмч болох, олдворуудыг судалж дууссаны дараа зохих хувийг Монгол руу буцаах, товч тайлан, газрын зураг, гэрэл зургийг Судар бичгийн хүрээлэнд хүлээлгэн өгөх, судалгааны үр дүнг хэвлүүлбэл 50 ширхгийг хэвлэх зэрэг асуудлыг тусгасан байна. Харин экспедицүүдийн зардал болон монголын талаас судалгааны ажилд хэрхэн оролцох талаар тусгасан зүйл ороогүй байна.

Харин 1930 оны 1 дүгээр сард Оросын ШУА-ийн Монголын комиссоос ШУА болон Судар бичгийн хүрээлэн хоёрын байгуулсан гэрээг биелүүлэх үүднээс Зөвлөлтийн ШУА, Монголын комиссоос шинжилгээний ангиуд Судар бичгийн хүрээлэнгийн үйл ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэх, бүх талын туслалцаа үзүүлэх үүргийг өөртөө авч байгаагаа мэдэгдсэн захидал ирүүлжээ.<sup>68</sup> Ингэснээр Оросын ШУА-иас Судар бичгийн хүрээлэнгийн үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэхээ албан ёсоор мэдэгдэж буй хэрэг байв. Энэ үйл явдал нь Монголд улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдсөний дээр 1930 онд Судар бичгийн хүрээлэн Шинжлэх ухааны хүрээлэн хэмээх нэртэй болж, Ерөнхий сайд асан А.Амар удирдах болсонтой холбоотой байв.

1930 онд гэрээнд заасан экспедицүүдээс 7 отряд Монголд ирж ажилласан юм. Үүнээс Я.И.Беляевын удирдсан астрономийн отряд Улаанбаатар, Ховд, Шаргын говь, Тайшир уулын чиглэлд явж судалгаа хийжээ.<sup>69</sup> Энэхүү судалгааны багийн урьдчилсан тайланд “13 хэсэг газрын газарзүйн координатуудыг нарийн тодорхойлон тогтоожээ. Судалгааны ажлын цаг мөчийг радио дохиогоор магадлах зэргээр үндэслэж маш нарийнаар явуулав. Түүнээс монгол оронд радио ажлыг хэрхэн явуулах ба радио холбоог хэрхэн байгуулж болох, монголын байдалд радио ямар аваарын хэрэгсэл хамгийн сайн тохирохыг магадлан илтгүүлэх зэргээр судлах туршлагаудыг гүйцэтгэв”<sup>70</sup> хэмээн бичжээ.

1930-1934 оны Монголын комиссын таван жилийн төлөвлөгөөг Судар бичгийн хүрээлэнтэй байгуулсан геологич И.П.Рачковскийн экспедиц 1930 онд хамгийн олон судлаачдын бүрэлдэхүүнтэй иржээ. Түүний отряд гурван хэсэгт хуваагдан явцгаажээ. Энэ удаагийн судалгааны ажлын зорилго нь, Монгол орны геологийн ерөнхий байдлыг илрүүлэн, орон нутгийн менериал баялагуудыг зохистойгоор бүртгэх авах, эдгээрийг ашиглаж болох эсэхийг магадлан үзэх байв.<sup>71</sup>

68 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Т. 106-107

69 Т.И.Юсупова. Монгольская комиссия Академии наук. История создания и деятельности 1925-1953. СПб., 2006. Стр. 236

70 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-304, хуудас 5

71 Мөн тэнд, хуудас 5

И.П.Рачковский Хан Тайшир, Хонгор, Баатар хайрхан зэрэг газруудаар явж, геологийн зураг үйлдсэн нь 3000 дөрвөлжин км болжээ. Монгол орны уурхайн баялагуудыг ашиглах, аж үйлдвэрийн байгуулгад эрхбиш чухалчлан гаргаваас зохих газрын хөрс, шороо давхаргыг судлахаас гадна зорчсон газарт хэдэн зүйлийн ашигтай уурхайн баялгуудыг илрүүлэв. Түүний дотроос ашиглахад хамгийн ашиг орлоготой нь төмөр ба мөн түүнийг дагалдах чулуун нүүрс болох болой. Төмөртэй газруудыг тус салаанаа нарийн тодорхойгоор судлан шинжилж Ховд хотын түлшний асуудлыг хангаж болох эсэхийг үзэхээр Баатар хайрханы чулуун нүүрстэй газрыг магадлан үзжээ.

Тус отрядын хоёрдугаар ангийг А.И.Педашенко удирдан явсан. Энэ анги геологийн хувьд огт судлагдаагүй байсан Шаргын говиос урагш Хятадын Шинжаан мужийн хил хүртэл Монгол Алтайг судлан шинжлэн үзжээ. Түүний судалгаа нь алтны талаар онц сонирхолтой хэмээн үзээд их голуудаар усны элс шороог давсаар 65 удаа туршин үзэж зэс, тугалга зэрэг өнгөт металлуудтай газруудыг илэрхийлж шинжилжээ.

Геологийн салбарын гуравдугаар салаа ангийг З.А.Лебедева удирдан явжээ. БНМАУ-ын Шинжлэх ухааны хүрээлэн, Эдийн засгийн зөвлөл, Худалдаа үйлдвэрийн яам зэрэг газруудтай ярилцан хэлэлцсэн ёсоор Улаанбаатар ба Налайхын чулуун нүүрсний уурхай зэрэг газарт ажлаа явуулжээ. Геологийн ерөнхий байдал ба тэр газрын тектоник хийгээд чулуун нүүрстэй газрын үе давхаргын мандал зэргийг магадлан илрүүлж, Улаанбаатар хотын барилгын явдалд туйлын хэрэгтэй болсон чулуун барилгын материалууд болох голын шохойг эрж олохоор ажиллажээ. Худалдаа үйлдвэрийн яаманд уурхайн зургийг малтсан газар ба тэмтрэн эгээрэх ажлуудыг цөмийг тэмдэглэж зохиож өгчээ. Мөн Налайхын Хонхорын захаар металлын марганецын ихээхэн хольцтой шинж бүхий орд, Цагаан булагт шохой малтаж байгаа газар ба Мандалд буй галд түлэгдэхгүй улаан шавартай газруудыг геологийн талаар тус тус үзэж тэндхийг аж үйлдвэрт ашиглан хэрэглэж болох эсэхийг барагцаалан үзэхээр хуучин Дэлгэрхангайн хошуунд зорьж очсон байна. “Геологийн отрядыг гурван анги болж явсан аливаа газруудаас геологийн цуглуулга хийж Шинжлэх ухааны хүрээлэнд илгээв” хэмээн товч тайланд дурджээ.<sup>72</sup>

Гидрогеологийн судалгааг химич А.Ю.Хами удирдан явуулжээ. Тэрээр В.А.Смирновын судалгааг үргэлжлүүлэн Улаанбаатар хотын ойролцоох ундны усны ундарга, нөөцийг судлан тогтоожээ.<sup>73</sup> Үүнд Туул, Улиастай, Сэлбэ голын ус ба бүх худгийн олонх хийгээд булгийн усыг хамруулсан байна. Эдгээр нь Улаанбаатар хотоос 20 км-ээс үл хэтэрнэ. Туул голын усны чанар онц сайн бөгөөд зөөлөн нь Нева мөрний усанд ойр бол Улиастай, Сэлбэ гол, бусад горхиудын ус нь Туул голын уснаас хоёр давхар ширүүн байна. Улаанбаатар олон худгийн ус нь азотын хүчил бүхий ба заримд нь аммиакийн шинжтэй тул дунд ба дээд зэргийн ширүүн

72 МУҮТА. ТБА. Х-23, Д-1, ХН-304, хуудас 6

73 Г.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. Стр.

ус хэмээн дүгнэжээ<sup>74</sup>. Үүнээс гадна БНМУА-ын таван жилийн төлөвлөгөөний дотор түүхий эд ба ноос арьс боловсруулах үйлдвэрийн газар ба эдгээр үйлдвэрт 1 600 000 кг ноос гаргахаар төлөвлөсөн учир үүнд хэрэглэгдэх усыг хаанаас яаж хангаж болох судалгааг хийж, зааварчилгааг гаргасан байна.<sup>75</sup>

Ботаникийн отряд хэд хэдэн чиглэлд ажиллахаар төлөвлөж байсан боловч Монголд цаг оройтож ирсэн учраас ганцхан чиглэлд ажиллажээ. Энэ отрядыг ботаникч Победимова удирдан Шаргын говиос урагш Монгол Алтайн нуруугаар явж судалгаа хийжээ. Судалгааны баг зорчин явсан газартаа нутгийн ардуудаас үнэн мэдээллийг авч газрын зураг дээр огт байдаггүй гол, усыг шинээр тэмдэглэн авч зураг үйлджээ. Мөн бэлчээрийн байдлыг тодорхойлон тэжээлийн ногоонуудыг бүртгэн, нутгийн ардуудын тариалангийн ажил, тэр дундаа хөрс боловсруулалт, цаг уурын байдлын ажиглалт, тариа будаагаа хэрхэн хураан авч буй зэрэг хөдөө аж ахуйн чиглэл давамгайлсан судалгааг хийжээ. Нийт 2000 орчим ургамлын хатаадас цуглуулснаас малын тэжээл ба эмд орох, үйлдвэрт ашиглагдах, зэрлэг ургаж буй ба тариалагдан буй тариа будаа зэрэг олон төрлийн ургамлыг хамруулж чаджээ. Жишээлбэл, үйлдвэрт ашиглаж болох каучукт ногоо байна хэмээн дүгнэсэн байна. Судалгаа явуулсан тухайн бүс нутагт ургац 7 сард дэлгэрэн ургаж, 8 сард хатах маш богино хугацаатай болохыг тодорхойлжээ.<sup>76</sup>

В.И.Барановын удирдсан хөрс, газар тариалангийн ангид зоотехникийн баг ажиллаж, мал аж ахуйн судалгааг хийжээ. В.И.Барановын отрядад хөрс судлаач В.И.Баранов, зоотехникч Н.А.Долгушина, агрономч Г.Е.Добровальский, Т.И.Гуляев нар ажилласан байна. Тус отряд Ховд ба Улаангомын хооронд хуучин Чандмань уулын аймгийн гурван хошуу ба 8 сум, Хан тайшир уулын аймгийн хоёр хошуунд тариалан эрхэлж болохоор шинэ газруудын хөрс шороо, ургамал ногооны зүйлсийг судалжээ. Хойт тал нь Буянт, Ховд гол хоёрын усны хагалбар, өмнө зах Цагаан дөш, зүүн зах Цэцэг нуур, баруун зах Булган гол, Бэйсийн хүрээ, Ховд хотын газар нутаг болж байв.

Тус отрядоос нийт 3000 орчим ургамлын хатаадас (гербари) цуглуулж, малын бэлчээр ба хадлангийн газруудыг тодорхойлж, явсан газар бүрийн ургамал, ногооны тодорхойлолтуудыг хийжээ. Хөрс шороог 100 гаруй удаа малтаж зүсэн үзэж, тариалахаар төлөвлөгдөн буй газруудаас дээж авч химийн анализ хийжээ. Тариа тарих, хадлангийн газрыг усны (30 гаруй) анализ үйлдэж, нутгийн ардуудаас тариалж байгаа улаан буудай, арвай, овьёос зэрэг хээрийн тариануудаас дээж авчээ. Явсан газар бүрдээ цаг уурын байдал, тариалах хугацаа, хөрс шороо ба тариалангийн газруудыг хэрхэн боловсруулан ажиллах, тариа будааг хэрхэн ээлжлэн олшруулж тарьдаг зэргийн тухай мэдээнүүдийг цуглуулснаас гадна аль нэгэн газрын хөрс шороо, ургамал, хөдөө аж ахуйн газруудын байдлыг тодорхойлох 250 орчим гэрэл зургийг буулган авсан байна.<sup>77</sup>

74 Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974. Баримт бичиг, материалын эмхтгэл 1 боть. 1921-1940. УБ., 1976. Тал 284

75 Мөн тэнд, тал 285

76 Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974. Баримт бичиг, материалын эмхтгэл 1 боть. 1921-1940. УБ., 1976. Тал 283-284

77 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-304, хуудас 7

Зоотехникийн мэргэжилтэн Н.А.Долгушина Чандмань уулын аймагт (Ховдын хязгаар) ажиллаж, тухайн бүс нутгийн таван хошуу малыг судалжээ. Тус зоотехникийн баг цөөн хүнтэйгээр хагас жилийн туршид мал аж ахуйн судалгааг явуулж, тухайн бүс нутгийг төлөөлөхүйц хэмжээний малыг судалгаанд хамруулжээ.<sup>78</sup>

1929 онд Улаанбаатар хотноо байгуулсан гэрээнд тусгагдаагүй боловч Монголын талын санал хүсэлтийг харгалзан үзээд гаргасан отряд бол И.Г.Дмитриевийн удирдсан Монголын эдийн засгийг судлах отряд юм. Тийм учраас уг отряд 1930 оны 9 дүгээр сард Монгол дахь судалгааны ажлаа эхлүүлсэн байдаг. Гэхдээ энэ судалгаа нь хээрийн судалгаа бус Улаанбаатар хотноо төвлөн тус улсын аж ахуй ба түүнийг нийгэм журмын ёсоор өөрчлөн сайжруулж байгуулах тухай материал цуглуулах, 1931 онд эдийн засгийн судалгааг хэрхэн явуулах ажлын төлөвлөгөөг боловсруулжээ. Шинээр байгуулагдаж буй хамтрал, сангийн аж ахуйнууд дээр очиж танилцан аж ахуй ба зохион байгуулалтыг хэрхэн явуулж буйг үзжээ. Мөн БНМАУ-ын Засгийн газраас 1930 оны 11 дүгээр сард хамтралын анхдугаар их хурал ба намын бага хуралд хамтрал, сангийн аж ахуйн чиглэлээр явуулах бодлого зорилтуудыг бэлтгэж өгчээ.<sup>79</sup>

Монголын комиссоос явуулж буй экспедицүүд судалгааны ажлаа Монголд явуулаад намар нь буцдаг байсан бол 1930 оноос зарим экспедицүүд нутаг буцалгүй Шинжлэх ухааны хүрээлэн болон Монголын бусад байгууллагуудын хүсэлтээр судалгааны ажлаа үргэлжлүүлж байв. БНМАУ-ын Засгийн газрын 1930 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Оросын ШУА-ийн Монголын комиссоос Монголд явуулсан экспедицүүдийн 1930 оны үр дүнг танилцуулжээ. Мөн 1931 онд явуулах ажлын төлөвлөгөөг сонсгосон байна. Түүний илтгэлээс сонсоод Засгийн газраас тусгайлан тогтоол гаргажээ. Энэ тогтоол дотроо 7 зүйлтэй аж. Тогтоолын агуулгыг хураангуйлбал, Зөвлөлтийн ШУА-иас ирүүлсэн эдгээр экспедицүүдийн судалгааны үр дүнг нь улсын аж ахуй ба аливаа салбарын байдал хэрхэн явж байгааг тодорхойлсноор аж ахуйн нийгэмчилсэн этгээдийн өсөлт, нэмэгдлийг шинжлэх ухаанаар баталж, зохион байгуулалтын төлөвлөгөөг зохион явуулахад хялбар болно. Шинжлэх ухааны судалгааны ажил явуулахад Монголын олон нийтийг татан оролцуулахыг баримтлан тэдгээрийн сонирхлыг сэргээх, ялангуяа орон нутгийн аж ахуйн газруудыг идэвхтэй оролцуулж хөгжүүлэхэд тус дөхөм болохыг тэмдэглэсэн байна. Эдгээр экспедицүүдийн ажилд 100 000 төгрөгөөс багагүй төсөв оруулахыг улсын төлөвлөгөөний комисст даалгасан байна. Мөн экспедицүүд хөдөө орон нутагт ажлаа гүйцэтгэн явж байхад орон нутгийн албан газрууд туслалцах ба хүлээн авах явдал хангалттай бус байсныг Засгийн газраас буруушаан тэмдэглэж, энэ ажилд тусллах нь “Улсын нийгэм журмын зохион байгуулалтыг үндэстэйгээр бататган хөгжүүлэхэд гүн холбогдсон туйлын чухал ажил болохыг төв ба орон нутгийн албан захиргааны газрууд ба ард олон хүлээн авч туслалцваас зохих”-ыг даалгасан

78 И.Ф.Шульженко. Животноводство Монгольской Народной Республики. М-Л, 1954. Стр. 4

79 Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974. Баримт бичиг, материалын эмхтгэл 1 боть. 1921-1940. УБ., 1976. Тал 285-286

байна. Эцэст нь Шинжлэх ухааны шинэ дүрмийн ёсоор геологийн отрядын удирдагч И.П.Рачковский, эдийн засгийн отрядын удирдагч И.Г.Дмитриев нарыг Шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүнээр сонгожээ.<sup>80</sup> Иймд И.П.Рачковский, И.Г.Дмитриев нар Шинжлэх ухааны хүрээлэнгийн тэргүүлэгчдийн хуралд тогтмол оролцож, тус хүрээлэнгийн үйл ажиллагаанд биечлэн оролцож, санал зөвлөмжийг өгөх болжээ. 1931 онд Монголын комиссоос Монголд явуулах экспедицүүдийг ерөнхийд нь И.Г.Дмитриев ахалж байсан бөгөөд мөн мал аж ахуйн отрядыг ерөнхийд нь удирдан явуулжээ. Энэ чиглэлийн судалгааг Монголын Засгийн газраас тусгайлан анхаарч ялангуяа БНМУА-д цаашид мал аж ахуйн ямар чиглэл тохиромжтой эсэхийг шинжлэх ухааны үүднээс судлуулахыг хүсэж байв.

1931 онд Монголд явуулах мал аж ахуй ба ургамал газар тариалангийн хээрийн судалгааны төлөвлөгөөг мөн оны 7 дугаар сарын 23-ны өдөр Шинжлэх ухааны хүрээлэнгийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн баталжээ. Мөн энэ хоёр экспедицийн хэрэгцээнд машин болон шатахууныг гаргаж өгсөн байна.<sup>81</sup> Монголын мал аж ахуйг судлах хээрийн шинжилгээний ажлыг хамгийн өргөн бүрэлдэхүүнтэйгээр явуулсан бөгөөд ахлагчаар нь генетикч Я.Я.Лус, бүрэлдэхүүнд нь Н.Н.Колесник, Б.П.Войтяцкий, Ю.Л.Горошенко, И.Ф.Шульженко, Е.М.Хейсин нар ажиллажээ. Шинжлэх ухааны хүрээлэнгээс Гомбо, Нацагдорж нарын оюутнуудыг дагалдуулан ажиллуулсан байна. Энэ отряд гурван анги болон хуваагдаж хээрийн судалгаа явуулав.

Профессор Я.Я.Лус Улаанбаатар, Булган, Улаангом, Өлгийн чиглэлд ажилласан бол хоёрдугаар ангийг Н.Н.Колесник ахлан Улаанбаатар, Өндөрхаан, Сүхбаатар, Чойбалсан, Улзын чиглэлд ажиллажээ. Харин гуравдугаар ангийг И.Ф.Шульженко ахлан Дорнод аймгийн Эрээнцавын дамжлага бааз, Хөвсгөл аймгийн Бургастайд үхэр ба хонины махны гарц ба чанарын судалгаа хийж, Улаанбаатар, Хатгал, Култук дахь мал нядалгааны газарт малын халдварт өвчний судалгаа хийжээ.<sup>82</sup> Энэ удаагийн экспедиц нь Монгол орны бүс нутаг бүрээс төлөөлүүлэн хамруулсан бөгөөд одоогийн Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв, Дундговь, Хөвсгөл, Завхан, Увс, Баян-Өлгий аймгуудын нутгийг хамарч, Монголын таван хошуу малын үр ашиг, түүний үүлдэр угсаа, махны гарц зэргийг судалжээ. Судалгааны үр дүнгийн талаар Я.Я.Лус, И.Ф.Шульженко, Я.Н.Колесник, В.Ф.Румянцев, В.И.Войтяцкий нарын “Монголын махны аж ахуй” (1933 он), “Монголын таван хошуу мал” 1936 он, “Монгол үхэр, түүний гарал” (1938 он), “Монгол ямаа” (1936 он) зэрэг олон бүтээлүүд хэвлэгдэн гарчээ.

Дараагийн томоохон бүрэлдэхүүнтэй отряд нь В.И.Барановын хөрс, газар тариалангийн судалгааны баг байв. Энэ отряд хоёр хэсэг хуваагдан судалгааны ажлаа явуулжээ. Хөрс судлаач С.И.Андреев, хөрс, ургамал судлаач Н.Л.Десяткин, агрономич Г.Е.Добровольский нар Сэлэнгэ аймагт байгуулагдсан Коминтерн (одоогийн Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суман дахь) сангийн аж ахуй, Хараа дахь улсын гурван аж ахуйн газрыг судалжээ. Харин В.И.Баранов, Ивановын хамт

80 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-196, хуудас 256-258

81 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-239, хуудас 13-14

82 И.Ф.Шульженко. Животноводство Монгольской Народной Республики. М-Л, 1954. Стр. 4

Улаангом, Ховдод газар тариалангийн газруудад судалгаа хийжээ.<sup>83</sup>

Эдийн засгийн отряд Монгол улсын Эдийн засгийн зөвлөлийн тусламжтайгаар өргөн бүрэлдэхүүнтэйгээр судалгааны ажил явуулав. Тус отрядыг П.В.Погорельский удирдан 14 хүний бүрэлдэхүүнтэй байсан бөгөөд өөрөө Улаанбаатар хотноо төвлөрөн судалгааны ажлаа явуулав. З.Н.Кубанин тэргүүтэй хоёр хүн Төв ба Тариалангийн аймгуудаар, В.М.Ваганов тэргүүтэй хүмүүс Дорнод ба Хэнтий аймгаар, И.А.Бородин тэргүүтэй хүмүүс Архангай аймгаар, өрнө зүгт В.М.Кудинов нар гэрэл зурагчны хамт судалгаанд явжээ.<sup>84</sup>

Геологийн судалгааны отряд мөн л өргөн бүрэлдэхүүнтэй ажилласан бөгөөд хоёр анги хуваагдсан байна. Тус отрядын удирдагч И.П.Рачковский, химич К.А.Ненадкевич, геологич П.П.Сизова нар Хөвсгөл, Дархадын хотгорт геологийн судалгаа хийж, зэсийн орд илрүүлсний дээр зарим эрдсийг шинжлэн үзжээ.<sup>85</sup> Харин хоёр дахь ангийг геологич З.А.Лебедева ахлан явсан байна. Түүний багийн бүрэлдэхүүнд байр зүйч М.П.Крупенин, В.С.Ивакин нар байснаас гадна Шинжлэх ухааны хүрээлэнгээс А.Д.Симуков, С.М.Ураков, Цэвэг Шалонов нар нэгдсэн байв.<sup>86</sup> З.А.Лебедева нар Алтай нурууны төгсгөл Гурван Сайхан уулын геологийн тогтцыг тусгайлан судалсан бөгөөд байр зүйн судалгааны баг хамт явсан учир энэ уулын байр зүйн зургийг тодорхойлжээ.

Ботаникийн отрядын хоёр анги ажиллаж, Е.Г.Победимовагийн удирдсан баг Дарьганга болон Сайр-Усны элсэн дэх ургамлыг судалсан бол Н.П.Иконников-Галицкий Гурван Сайхан ууланд ажилласан байна.<sup>87</sup>

Тэгвэл Е.В.Козловагийн удирдсан зоологийн отрядад Шинжлэх ухааны хүрээлэнгээс В.М.Канаев дагалдан явжээ. Тэд Хэнтийн нурууны өндөр уулын болон ойн шувуудыг судалсны дээр Шинжлэх ухааны хүрээлэнгийн хүсэлтээр Хэрлэн голын аж ахуй, тэр дундаа загас агнуурын байдлыг судалжээ.<sup>88</sup>

1931 онд ЗХУ-ын ШУА-ийн “Монголын комисс”-оос Монголд явуулсан судалгааны ажлын урьдчилсан дүнг Монгол дахь экспедицүүдийн ахлагч И.Г.Дмитриев 1932 оны 3 дугаар сарын 14-н МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгч нарт танилцуулжээ. Төв Хорооноос судалгааны үр дүнг нь хөгжиж буй БНМАУ-ын аж ахуйн байгуулалтад өргөн хүрээтэй бүрэн дүүрэн ашиглаж болохыг тэмдэглээд тусгайлсан тогтоол гаргажээ. Үүнд,

- БНМАУ-ын мал аж ахуй, сүргийн бүтэц, түүнийг хөгжүүлэх арга зам, газарзүйн хуваарилалт, бүсчлэлийн ялгаа, үүлдэр угсаа, үр ашгийг сайжруулах арга замыг анх удаа тодорхойлов.

83 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Т. 142

84 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Т. 142-143

85 Т.И.Юсупова. Монгольская комиссия Академии наук. История создания и деятельности 1925-1953. СПб., 2006. Стр. 69

86 З.А.Лебедева. К геологии горной группы Гурбан-Сайхан в Гобийском Алтае. Труды Монгольской комиссий №18. Л., 1934. Стр. 1

87 Т.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. стр. 141

88 Так же. Стр. 269

- Хамтрал, улсын аж ахуйн хөрс, геоботаникийг судалж тусгайлсан зураг гаргав.
- Монгол орны геологийн газрын зураг хийхэд урьд нь цуглуулсан материал дээр нэмэр болох үнэ цэнтэй материалуудыг цуглуулсан.
- Өмнөговийн усны нөөцийн судалгааг хийсэн.
- Хамтрал, улсын аж ахуйн өнөөгийн байдал, тэднийг хөгжүүлэн бэхжүүлэх ирээдүйг тодорхойлсон материалууд, хүн амын нийгмийн давхраа<sup>89</sup> зэргийг судалсан маш үнэтэй судалгаа болсныг онцлон тэмдэглэсэн байна.

1932 онд явуулах судалгааны ажлыг үргэлжлүүлэхэд санхүүгийн хувьд боломжтой болгосон төсвийг боловсруулан Намын Төв Хороогоор батлуулахыг Засгийн газарт даалгаснаас гадна судалгааны үр дүнг хүмүүст таниулах ажлыг зохион байгуулах ажлыг Шинжлэх ухааны хүрээлэнд хариуцуулжээ.<sup>90</sup> 1932 оны эхээр ЗХУ-ын ШУА-ийн дэргэдэх Монголын комиссын удирдлага ба бүрэлдэхүүнд өөрчлөлт оров. Комиссыг академич Л.В.Комаров тэргүүлэх болсон бол нарийн бичгийн даргаар профессор И.П.Рачковский томилогдсон байна. Мөн Шинжлэх ухааны хүрээлэнгийн захирал А.Амарыг гишүүнд сонгон оруулав. Энэ нь Монголын комиссын Монгол дахь үйл ажиллагааны гол тулгуур болсон Шинжлэх ухааны хүрээлэнтэй нягт ажиллаж байгааг илтгэж буй хэрэг байв. Шинжлэх ухааны хүрээлэнгийн дарга А.Амараас ЗХУ-аас БНМАУ-д суух элчин В.Х.Таировд бичсэн захидалд мал аж ахуй (өвс тэжээлийн), геологийн, хэл шинжлэл-археологийн отрядуудыг Монголд явуулахыг хүссэн байна. Шинэ удирдлага, бүрэлдэхүүнтэй болсон Монголын комиссоос 1932 онд ганцхан геологийн отрядыг Монгол руу явуулж чаджээ.<sup>91</sup> Монголын комиссын нарийн бичгийн даргаар сонгогдсон И.П.Рачковский 1932 оны зун Монголд ирсэн боловч өөрөө судалгааны ажилд явсангүй харин геологич И.П.Сизовагаар ахлуулан нэг отрядыг хээрийн судалгаанд гаргажээ. И.П.Сизова судалгааны ажилдаа зарцуулах 6000 төгрөгийг гаргаж өгөхийг Шинжлэх ухааны хүрээлэнгээс хүсжээ.<sup>92</sup> Геологийн отрядын П.И.Сизова тэргүүтэй хүмүүс Хэнтийн нурууны салбар уул Өрмөгтэй уул, өмнөд Монголын Хавтгай ууланд геологийн судалгаа явуулж, зэсийн хүхэрт давсны тархац бүхий маш сонирхолтой ордыг нээн илрүүлсэн хэмээжээ.<sup>93</sup>

1933 онд Монголын комиссоос дахин ганцхан геологийн отрядыг Монголд ажиллуулахыг зөвшөөрчээ. Энэ отрядыг И.П.Рачковский өөрөө удирдан өргөн бүрэлдэхүүнтэйгээр Монголд геологийн судалгаа явуулжээ. Багийн бүрэлдэхүүнд геологичдаас гадна байр зүй, одон орон судлалын судлаачид багтсан байна. Үүнд, геологич З.А.Лебедева, П.П.Сизова, байр зүйч М.П.Крупенин, техникч

89 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Т. 144

90 Мөн тэнд, т. 145

91 Т.И.Юсупова. Советско-Монгольское научное сотрудничество. становление, развитие и основные результаты. 1921-1961. СПб., 2018. Стр. 147

92 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-336, хуудас 38

93 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Т. 178

А.Л.Смольянинова нар явжээ. И.Г.Рачковскийн төлөвлөснөөр тус отряд дөрвөн ангид хуваагдан ажиллах ба Дархадын хотгорт 1-2 сар, Тариатын бүс нутагт 1 сар, Чулуут гол, Хангайн нурууг хөндлөн огтолож Заг, Байдрагт 1 сар, Хангайн нуруу ба Говийн өмнөд хэсэгт 1-0.5 сар ажиллах. Үндсэн ангиас бусад гурван анги нь хөнгөн ачаа тээштэйгээр 1 геологич, 1 цуглуулагч, 1 орчуулагч, 2 ажилтантай байх. Үндсэн отряд Цэцэрлэгийн бүс нутгаас бусад ангиудтай нэгдэн Улаанбаатарт 9 сард хүрэлцэн ирэхээр төлөвлөхөд нийт зардал 23430 төгрөг болохыг тооцоолсон байна.<sup>94</sup>

Судалгааны үр дүнд Хангайн нурууны өндөрлөг газар, Говь-Алтайн налсан хэсгийг судалж, Монгол-Сибирийн талбайн ихэнх хэсгийн царцдасын олон асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий сонирхолтой баримтуудыг олж авчээ. Дархадын хотгорт хийсэн судалгаагаар Зөвлөлтийн Соёны газарзүйн мужийн геологийн тогтоцтой нягт уялдаатай байгааг илрүүлжээ.<sup>95</sup> 1923 оноос 1933 он хүртэлх И.П.Рачковскийн отрядын Монголд хийсэн геологийн судалгааны үр дүн нь Монгол улсын геологийн судалгааны цаашдын хэтийн төлвийг урьдчилан таамаглаж болохуйц судалгаа явагдсан хэмээн дүгнэжээ.

И.П.Рачковскийн 1933 оны геологийн отрядын Монголд явуулсан судалгаагаар 1929 онд хоёр улсын шинжлэх ухааны байгууллагуудын байгуулсан 1930-1934 онд таван жилийн төлөвлөгөөг баталсан гэрээний хугацаа дуусчээ. Энэ таван жилийн хугацаанд Монголд явуулсан ажил нь урьд өмнө, дараа нь ч байгаагүй маш өргөн хүрээг хамарсан, олон судлаачдыг оролцуулсан судалгаа байв. Уг нь байгалийн ухааны олон чиглэл, дээрээс нь нийгмийн ухааны хэл шинжлэл, археологийн экспедицүүд анхны төлөвлөгөөнд орж батлагдсан боловч БНМАУ-ын Засгийн газрын санал хүсэлтийг харгалзан мал аж ахуй, газар тариалан, хөдөө аж ахуйн эдийн засгийн судалгааг нэмэлтээр оруулж явуулсан юм. Энэ нь БНМАУ-ын зорилт болгон дэвшүүлсэн “ард түмний аж ахуйг нүүдлийн байдлаас суурин байдалд оруулах, тэдгээрийн аж ахуйг хамгийн дээд хэлбэр маягийн хамтарсан аж ахуй болгох, газар тариаланг хөгжүүлэхдээ талх тариагаар өөрийн дотоод хэрэгцээг хангах, аж үйлдвэрийг хөгжүүлэхдээ үйлдвэрлэлийн багаж хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх”<sup>96</sup> зорилтыг хангахын тулд дээрх чиглэлүүдэд тухайн цагийн Монголын нам, засгаас анхаарлаа хандуулсантай шууд холбоотой юм.

1935 онд “Монголын комисс” гишүүдийн тоог нэмж, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө таван жилээр боловсруулах ажлыг эхлүүлжээ. Гишүүдэд Шинжлэх ухааны хүрээлэнгийн дарга Л.Дэндэв, Ленинград хотноо эрдмийн ажлаа хийж байсан Ж.Цэвээн нарыг оруулсан байдаг. Шинжлэх ухааны хүрээлэнгээс ч Монголын комисс руу захидал илгээн хамтран ажиллах, мөн шинжлэх ухааны чиглэлээр экспедицүүдийг Монголд ирүүлэх санаалаа удаа дараа гаргаж байв.

ЗХУ-ын ШУА-ийн дэргэдэх Монголын комисс ч дараагийн таван жилийн төлөвлөгөөгөө боловсруулан олон чиглэлийн судалгааг явуулахаар байр зүйн хэсэг

94 МУУТА. ТБА. Х-23, Д-1, ХН-336, хуудас 8-9

95 Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Т. 178-179

96 Намын VIII их хурал

бүхий геологи, хөдөө аж ахуй, мал аж ахуй, өвс тэжээл, ботаник, түүх-археологи, угсаа-хэл шинжлэлийн отрядуудыг явуулахаар баталжээ.<sup>97</sup> Гэсэн хэдий ч ЗХУ-ын Ардын Комиссариатын Зөвлөлөөс санхүүгийн асуудлыг шийдвэрлэж өгөөгүй учир дээрх төлөвлөгөө биеллээ олох боломжгүй болжээ. Дээрх шалтгаанаар 1940 он хүртэл Монголын комиссоос дахин судалгааны экспедицүүдийг явуулаагүй юм.

Нэгэнт Монгол руу явуулах судалгааны багуудыг илгээх явдал нь бүтэлгүй болсон учир ЗХУ-ын ШУА-ийн хүрээлэнгүүдээс Монголын Шинжлэх ухааны хүрээлэнтэй шууд харилцан холбоо тогтоох, хамтран ажиллах, судлаач солилцох зэрэг асуудал руу орсон байна.

1923 оноос эхлэн 1933 оны хугацаанд 13 шинжлэх ухааны чиглэлээр 40 гаруй отрядын 60 гаруй анги Монгол орны газар бүр судалгаа явуулжээ.

“Монголын комисс”-оос зохион байгуулагдсан эдгээр олон судалгааны экспедицүүдийн үр дүнд, монголчуудын хувьд геологийн судалгааг үргэлжлүүлэх сонирхолтой байсан бөгөөд арван жилийн хугацаанд Монголын комиссоос явуулсан геологийн судалгааны үр дүнд хуучин “Монголор”-ын ашиглаж байсан ихэнх алтны уурхайн нөөцийг тогтоолгож, ховор ба үнэт ховор металлуудын зарим ордуудыг урьдчилсан байдлаар илрүүлсэн юм. Үүний үр дүнд Улаанбаатар хотыг шинээр төлөвлөн барилга байгууламжийг барихад ашиглахад хэрэглэгдэх барилгын материалуудыг ашиглаж эхэлжээ. Тэрчлэн Улаанбаатар хотын албан байгууллага, хүн ардын түлшинд хэрэглэх модыг багасгах зорилтын хүрээнд Налайхын чулуун нүүрсний нөөцийг тогтоолгож, ашиглах хялбар арга замыг боловсруулсан юм.

Улаанбаатар хот ба тал хээр, говийн бүс нутагт усны нөөцийн судалгааг явуулснаар хотын иргэдийн усны хэрэгцээг хангах, ирээдүйн төлөв байдлыг тодорхойлж, говийн бүсийн худаг усны ажлыг сайжруулах шаардлага байгаатайг тодорхойлжээ.

1929 оноос эхлэн Монгол оронд олноор байгуулагдсан хамтрал, коммун, улсын аж ахуй эдийн засгийн үндсийг судлуулж, газар тариалан эрхэлж буй газрын хөрсний чанарыг тогтоож, монгол малын үүлдэр угсааг тодорхойлж, сайжруулах арга замыг анх удаа тодорхойлуулжээ. Энэ мэтчилэн “Монголын комисс”-ын судалгааны үр дүнд шинжлэх ухааны үндэстэй мэдлэгийг ашиглан өөрийн улсын дэвшүүлж буй зорилтод хүрэх хэрэгтэй гэдгийг нам, төрийн удирдлагууд хүлээн зөвшөөрсөн юм. Тийм учраас шинжлэх ухааны мэдлэгийг ард олонд ойлгуулан, таниулах ажлыг эрчимтэй хийхийг Шинжлэх ухааны хүрээлэнд тусгайлан даалгасан байдаг.

ЗСБНХУ-ын “Монголын комисс”-оос 1923 оноос эхлэн 1933 оны хугацаанд 13 шинжлэх ухааны чиглэлээр 40 гаруй отрядын 60 гаруй анги Монгол орны газар бүр судалгаа явуулсан нь БНМАУ-ыг шинжлэх ухааны олон төрлөөр судалгааны бүтээлүүд хэвлэгдэж, улс орны эдийн засаг, аж ахуй, соёлын хөгжилд зохих хувь нэмрээ оруулсан байна.

<sup>97</sup> Монгол-Оросын шинжлэх ухаан, соёлын харилцаа. Архивын баримтын эмхтгэл. (1921-1960). Боть I. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2011. Т. 178-179